

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр, Даваа гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-7

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 8-31

1. “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2022.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ 8-14
14-31

2. Хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн талаарх Төрийн албаны зөвлөлийн 2023 оны тайлан

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
04 дүгээр сарын 15-ны өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 19 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Ж.Батсуурь, Д.Сарангэрэл;
Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ, М.Оюунчимэг.

Нэг.“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2022.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын референт Д.Ганбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын шинжээч Г.Дөлгөөн, Удирдлагын академийн Удирдлага, сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор Г.Жаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд танилцуулав.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Н.Энхболд: 1.Тогтоолын төслийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн хавсралтын 1.1, 1.3 дахь заалтыг нэгтгэн 1.1 дэх заалт болгон доор дурдсанаар өөрчлөх:

“1.1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.3 дахь хэсэгт заасан аймаг, сум, дүүрэг /цаашид “нэгж” гэх/-ийг өөрчлөх асуудлыг санаачлах, нэгжийн өөрчлөлтийн төсөл боловсруулах, иргэдийн санал авах үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн хавсралтын 2.1.6 дахь дэд заалтын “тухайн орон нутгийн нутаг дэвсгэр (газар, хилийн цэс), хүн ам зүй” гэснийг “өөрчлөлтөд хамрагдах нэгжийн одоогийн болон өөрчлөлтийн дараах нутаг дэвсгэр, хилийн цэс, хүн ам” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн хавсралтын 2.1.5 дахь дэд заалтын “зогсоож, өөр нэгжид (аймаг, сум, дүүрэг) нутаг дэвсгэр, засаг захиргааны хувьд харьяалуулахыг” гэснийг “зогсоохыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн хавсралтын 2.1.1 дэх дэд заалтын “хуваах” гэсний дараа “, шилжүүлэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн хавсралтад доор дурдсан агуулгатай 2.1.5 дахь дэд заалт нэмэх:

“2.1.5.“нэгжийг шилжүүлэх” гэж тухайн нэгжийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн харьяаллыг өөрчлөхийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн хавсралтын 3.1.1 дэх заалтын “газар зүй” гэснийг “газар зүйн онцлог, орон зайн байршил,” гэж, 3.1.2 дахь заалтын “дэвсгэрийн хувьд” гэснийг “дэвсгэр” гэж,

3.1.4 дэх заалтын “нутгийн” гэснийг “орон нутгийн” гэж, 3.1.5 дахь заалтын “угсаатан зүй” гэснийг “угсаатны онцлог” гэж, 3.1.6 дахь дэд заалтын “ашиг, өгөөжтэй” гэснийг “ашигтай” гэж тус тус өөрчилж, 3.1.6 дахь дэд заалтын “эдийн засгийн” гэсний өмнө “нийгэм,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн хавсралтын 3.1.3 дахь дэд заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төслийн хавсралтад доор дурдсан агуулгатай 4.1, 4.2 дахь заалт нэмэх:

“4.1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 13.2-г заасны дагуу аймаг, сум, дүүргийг өөрчлөх асуудлыг Засгийн газар санаачилна.

4.2.Нэгжийн өөрчлөлтийн төслийн баримт бичгийг төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, өөрчлөлтөд хамрагдах нэгжийн Засаг даргын Тамгын газрын төлөөллөөс бүрдсэн Ажлын хэсэг боловсруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төслийн хавсралтын 4.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 4.4 дэх заалт болгох:

“4.4.Ажлын хэсэг нэгжийн өөрчлөлтийн төсөл боловсруулахдаа энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан мэдээллийг тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төслийн хавсралтын 4.5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төслийн хавсралтын 4.1.3 дахь дэд заалтын “хөдөлгөөнийг” гэснийг “хөдөлгөөний хандлагыг” гэж, 4.1.5 дахь дэд заалтын “төрийн” гэснийг “иргэдэд зориулсан төрийн” гэж, мөн дэд заалтын “үйлчилгээ иргэдэд хүртээмжтэй” гэснийг “үйлчилгээний чанар, хүртээмж өмнөх түвшнээс дээшилсэн” гэж тус тус өөрчилж, 4.1 дэх хэсгийн “Засгийн газар, түүний харьяа яам, агентлаг” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Төслийн хавсралтын 5.1 дэх заалтын “үнэлгээ” гэснийг “шинжилгээ” гэж, 5.3 дахь заалтын “дүүргийн хувьд” гэснийг “дүүргийг” гэж, мөн заалтын “аймгийн хувьд” гэснийг “аймгийг” гэж, 5.4 дэх заалтын “асуудлын талаар иргэдээс өөрчлөлтийг “дэмжиж байна”, “дэмжихгүй” гэсэн томьёоллоор санал” гэснийг “асуудлаар иргэдийн саналыг энэ журмын хоёрдугаар хавсралтад заасан саналын хуудсаар” гэж, 5.5 дахь заалтын “сонгуулийн насны иргэдийн олонх оролцсон бол санал авах ажлын дүнг” гэснийг “сонгуулийн эрх бүхий иргэд оролцох бөгөөд олонх нь оролцсон бол санал хураалтыг” гэж, 5.10 дахь заалтын “хураалтын нэгдсэн дүнг санал хураалтаас хойш” гэснийг “хураалт дууссаны дараа саналын хуудсыг тоолж, дүнг” гэж, 5.11 дэх заалтын “5” гэснийг “3” гэж тус тус өөрчилж, 5.10 дахь заалтын “нэгдсэн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Төслийн хавсралтад доор дурдсан агуулгатай 5.4, 5.5, 5.6 дахь заалт нэмэх:

“5.4.Аймгийг өөрчлөх асуудлаар Засгийн газар энэ журмын 5.3-т заасан хугацаанд багтаан санал хураалт явуулах байршил, өдөр, цагийг товлон зарлана.

5.5.Сум, дүүргийг өөрчлөх асуудлаар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ журмын 5.3-т заасан хугацаанд багтаан санал хураалт явуулах байршил, өдөр, цагийг товлон зарлана.

5.6.Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нэгжийг өөрчлөх асуудлаар санал хураалтыг урьдчилан тогтоосон байранд, битүүмжилсэн саналын хайрцганд нууцаар авна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Төслийн хавсралтын 5.3 дахь заалтын “арга хэмжээг” гэсний дараа “энэ журмын 4.2-т заасан ажлын хэсэг нэгжийн өөрчлөлтийн төслийн баримт бичгийг боловсруулан хүлээлгэн өгснөөс хойш” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төслийн хавсралтын 5.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.7.Өөрчлөлтөд хоёр ба түүнээс олон нэгж хамрагдах тохиолдолд тухайн өөрчлөлтөд хамрагдаж байгаа нэгжүүдийн санал хураалтад оролцсон нийт иргэдийн олонх дэмжсэн саналыг хүчинтэйд тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Төслийн хавсралтын 5.8 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журмын төслийн 1 дүгээр хавсралтын 1.4 дэх мөрний “асуудал” гэсний дараа “/өөрчлөх болсон үндэслэл, шалтгаан/” гэж, 1.5 дахь мөрний “хуваах” гэсний дараа “шилжүүлэх” гэж, 3.1 дэх мөрний “Хучилттай” гэсний өмнө “Хатуу” гэж, 4.2 дахь мөрний “Боловсрол” гэсний дараа “Мэргэжлийн сургалтын байгууллагын тоо, хүчин чадал, хамрагдалт, орон тоо” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журмын төслийн 1 дүгээр хавсралтын гарчгийн “ТАЛААРХ” гэснийг “ТӨСЛИЙН” гэж, 1.1 дэх мөрний “Харьяалал /аймаг, сум, нийслэл, дүүрэг” гэснийг “Нэгжийн харьяалал /аймаг, дүүрэг/” гэж, 1.2 дахь мөрний “Тухайн нэгж” гэснийг “Нэгжийн нэр” гэж тус тус өөрчилж, 2.1 дэх мөрний “/2010, 2020 он/” гэснийг, тайлбар хэсгийг “агентлаг” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журмын төслийн 2 дугаар хавсралтын "...аймгийн ... сумыг /дүүрэг/" гэснийг "... засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг" гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн "дэмжсэн" санал техникийн саатлын улмаас "эсрэг" гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 11 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журмын төслийн 2 дугаар хавсралтын "хуваах" гэсний дараа " , шилжүүлэх" гэж тус тус нэмж, "татан буулгах," гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Тогтоолын төслийн болон хавсралтын талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томьёог жигдлэх, заалт, дэд заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх, агуулгыг алдагдуулахгүйгээр хүснэгтийн загварыг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн талаарх Төрийн албаны зөвлөлийн 2023 оны тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, мөн зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс, Д.Баатарсайхан, В.Жавзан, Б.Идэрчулуун, Б.Пүрэвдагва, Сонгон шалгаруулалтын газрын дарга Т.Сосорбарам, Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын дарга О.Чинзориг, Захиргаа, удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Гантулга, Хүний нөөцийн удирдлага аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нармандах, Захиргаа, удирдлагын газрын мэргэжилтэн Т.Сайхнаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Г.Болорсүх, мөн хэлтсийн Хяналт шинжилгээ, үнэлгээний албаны референт Б.Буянзаяа нар байлцав.

Хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн талаарх Төрийн албаны зөвлөлийн 2023 оны тайланг Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, тус тайланд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын хийсэн хяналт, шалгалтын талаарх дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд нар танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Н.Энхболд нарын тавьсан асуултад Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, мөн зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс, Б.Идэрчулуун нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн талаарх Төрийн албаны зөвлөлийн 2023 оны тайланг сонсов.

Уг асуудлыг 15 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 35 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр 15 цаг 54 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Үндсэн хууль”
танхим
14 цаг 19 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Ирц бүрдсэн байна. Ингээд Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 4 сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Хэлэлцэх асуудлаа танилцуулъя. Өнөөдөр хоёр асуудал байгаа.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах, журам батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газар 22 оны 1 сарын 5-ны өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг хийнэ. Ажлын хэсэг гараад Ганболд гишүүн ахлаад, зарчмын зөрүүтэй зарим саналууд оруулж ирсэн байгаа. Их Хурлын удирдлагын зүгээс бас энэ журмыг ямар ч байсан ярьчихъя гэсэн чиглэл өгсөн учраас Даргын зөвлөл дээр шийдээд энийг оруулж байгаа.

Хоёрдугаарт, Хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн талаарх Төрийн албаны зөвлөлийн 2023 оны тайлан сонсоно. Дэгээрээ Байнгын хороо хэлэлцээд, тайлан сонсоод шаардлагатай гэж үзвэл нэгдсэн чуулганд санал, дүгнэлт оруулдаг. Сонссон гээд үзчихвэл Байнгын хорооны хэмжээнд сонслоо болно гэж үзвэл Байнгын хороон дээрээ хэлэлцээд, хуулийн заалт хэрэгжих ийм агуулгатай зохицуулалт бий.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу? Алга байна. Асуудалдаа оръё. Тэгвэл Төрийн албаны зөвлөлийнхөн маань түр гараад хүлээж

байх уу? Бид нар эхлээд журмаа ярьчихаад та бүхнийг дуудчихъя. Та нар ойрхон байж байгаарай. Тийм.

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Анхны хэлэлцүүлэгт бэлтгэж, Ганболд гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг ажилласан. Чуулганы дэгийн тухай хуулийн 94.1-д тогтоол гаргахаар бол хэлэлцэх эсэх, анхны болон эцсийн хэлэлцүүлгийн үе шаттайгаар хэлэлцэн шийдвэрлэх бөгөөд энэ хуульд заасан хууль, тогтоолын төслийг хэлэлцэх журмыг баримтална гэсэн байгаа. Ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ганболд хийнэ. Ганболд гишүүний микрофоныг өгье.

Г.Ганболд: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газраас 2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр “Журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд үүнд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд Улсын Их Хурал батлахаар заасан 3 журмын төсөл болно.

Улсын Их Хурал батлахаар заасан дээрх журмуудаас ИТХ-ын зөвлөлийн ажиллах журмыг 2022 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр баталсан болно.

Төрийн байгуулалтын байнгын хорооноос төслийг хэлэлцүүлэгт бэлдэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ганболд, Сүхбаатар, Баатарбилиг нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ажлын хэсгийг 2024 оны 4 дүгээр сарын 2, 4 дүгээр сарын 3-ны өдрүүдэд хуралдан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журмын төсөлтэй холбогдуулан 22

зарчмын зөрүүтэй санал томъёолол бэлтгэлээ.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол нь дараах үүрэг хүрээг хамарсан болно. Үүнд:

1.Тогтоолын төслийг 2 дахь заалт буюу дагаж мөрдөх хугацааг хасаж, тогтоол ердийн журмаар хүчин төгөлдөр болох.

2.Тогтоолын хавсралтын нэр томъёоны тодорхойлолт гэсэн нэгжийг шилжүүлэх гэсэн нэр томъёог нэмж тусган, нэгжийн өөрчлөлтийн төслийн баримт бичигт тухайн өөрчлөлтөд хамрагдаж байгаа нэгжийн одоогийн болон өөрчлөлтийн дараах нөхцөл байдлыг тусгасан байхаар тодруулах.

3.Тогтоолын хавсралтын нийтлэг үндэслэл хэсэгт энэ журмаар зохицуулах харилцаатай холбогдох заалтуудыг нэгтгэн томъёолж, төслийн хавсралтын бусад заалт, дэд заалтыг нийцүүлэн өөрчлөх, нэгжийн өөрчлөлтийн талаарх төсөл боловсруулах иргэдэд зориулсан төрийн болон орон нутгийн ажил, үйлчилгээний чанар, хүртээмж өмнөх түвшинээс дээшилсэн байх.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журмыг хавсралтаар батлах.

Төслийн баримт бичигт тусгагдах үндсэн мэдээлэл, иргэдээс санал авах саналын хуудасны загварт өөрчлөлт оруулж, журмыг холбох заалтад нэмж тусгах.

Нэгжийн өөрчлөлтийн төслийг боловсруулах ажлын хэсэгт тухайн нэгжийн төлөөлөл оролцох агуулгыг тодруулж, үйлчлэлд хамрагдах нэгжийн ЗДТГ-ын төлөөллийг оролцуулах.

Сум, дүүргийн хувьд 3 сар, аймгийн хувьд 6 сарын хугацаанд багтаан иргэдэд мэдээлэх, танилцуулах,

оролцогч талуудын уулзалт хэлэлцүүлэг, нөлөөллийн шинжилгээ хийх, иргэдээс санал авах, дүнг нэгтгэн мэдээлэх ажлыг зохион байгуулахаар төсөлд тусгасан бөгөөд тус 3 сар, 6 сарын хугацааг ажлын хэсэг нэгжийн өөрчлөлтийн төслийн баримт бичгийг боловсруулан хүлээлгэн өгснөөс хойш тооцохоор тодруулах.

8.Аймгийг өөрчлөх асуудлаар санал хураалт явуулах өдөр, цагийг Засгийн газар сум, дүүргийг өөрчлөх асуудлаар санал хураалт явуулах өдөр, цагийг аймаг, нийслэлийн ИТХ товлон зарлах, саналыг нууцаар авах.

9.Өөрчлөлтөд 1, эсвэл 2 ба түүнээс дээш нэгж хамрагдах тохиолдолд тухайн өөрчлөлт хамрагдаж байгаа нэгжүүдийн санал хураалтад оролцсон нийт иргэдийн олонх дэмжсэн саналыг хүчинтэйд тооцох хүрээнд зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлтгэсэн болно.

Байнгын хорооны гишүүд ээ,

Улсын Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журмын төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Баярлалаа.

Н.Энхболд: Ганболд даргад баярлалаа. Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулж асуух гишүүн байна уу?

Алга байна.

Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй саналууд томъёолж, Байнгын хорооны хуралдаанд ирүүлсэн байгаа. Энэ саналуудаар санал хурааж эхэлнэ. Өнөөдрийн хэлэлцүүлэгт оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя.

Засгийн газрын Хэрэг эрлэх газрын Орон нутгийн удирдлагын газрын референт Ганбат алив? Ганбат. Засгийн газрын Хэрэг эрлэх газрын Хууль, эрх зүйн газрын шинжээч Дөлгөөн? Дөлгөөн ирсэн байна. Удирдлагын академийн удирдлага сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор Жаргал? Жаргал доктор ирсэн байна.

Санал хураах ажилдаа орёе доо. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудаар санал хурааж эхэлье.

1 дүгээрт, Тогтоолын төслийн 2 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсгийн гишүүд Ганболд, Баатарбилиг, Сүхбаатар цаашид ажлын хэсэг гэнэ. Саяын томъёоллоор санал хураалт явуулъя. Хоёрдугаар заалтыг хасах. Санал хураалт. Гялалзуулна хэдүүлээ.

11 гишүүн оролцож, 6 дэмжиж, 54.5 хувиар энэ санал дэмжигдэж байна.

2.Төслийн хавсралтын 1.1, 1.3 дахь заалтыг нэгтгэн 1.1 дэх заалт болгон доор дурдсанаар өөрчлөх:

“1.1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.3 дахь хэсэгт заасан аймаг, сум, дүүрэг /цаашид “нэгж” гэх/-ийг өөрчлөх асуудлыг санаачлах, нэгжийн өөрчлөлтийн төсөл боловсруулах, иргэдийн санал авах үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна”. Ажлын хэсгийн гаргасан санал. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт 11-ээс 6 гишүүн дэмжиж, 54.5 хувиар дэмжигдэж байна санал.

3.Төслийн хавсралтын 2.1.6 дахь дэд заалтын “тухайн орон нутгийн нутаг дэвсгэр (газар, хилийн цэс), хүн ам

зүй” гэснийг “өөрчлөлтөд хамрагдах нэгжийн одоогийн болон өөрчлөлтийн дараах нутаг дэвсгэр, хилийн цэс, хүн ам” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн санал, дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт.

11-ээс 7 дэмжиж, 63.6 хувиар дэмжигдлээ.

4.Төслийн хавсралтын 2.1.5 дахь дэд заалтын “зогсоож, өөр нэгжид (аймаг, сум, дүүрэг) нутаг дэвсгэр, засаг захиргааны хувьд харьяалуулахыг” гэснийг “зогсоохыг” гэж өөрчлөх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт.

11-ээс 7 дэмжиж, 63.6 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн хавсралтын 2.1.1 дэх дэд заалтын “хуваах” гэсний дараа “, шилжүүлэх” гэж нэмэх. Ажлын хэсгийн санал дэмжье. Санал хураалт. Цөөн хүн амтай газрын саналыг заримыг нь ахиулж тооцох энэ тэр заалтууд орж байгаа шүү дээ.

11-ээс 7, 63.6 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн хавсралтад доор дурдсан агуулгатай 2.1.5 дахь дэд заалт нэмэх:

“2.1.5. “нэгжийг шилжүүлэх” гэж тухайн нэгжийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн харьяаллыг өөрчлөхийг;”. Санал гаргасан ажлын хэсэг, дэмжье. Санал хураалт.

11-ээс 6 дэмжиж, 54.5хувиар санал дэмжигдлээ.

Ганболд гишүүн өөрөө ярьж байгаад хоцорчихсон байна шүү.

7.Төслийн хавсралтын 3.1.1 дэх заалтын “газар зүй” гэснийг “газар зүйн онцлог, орон зайн байршил,” гэж, 3.1.2 дахь заалтын “дэвсгэрийн хувьд” гэснийг

“дэвсгэр” гэж, 3.1.4 дэх заалтын “нутгийн” гэснийг “орон нутгийн” гэж, 3.1.5 дахь заалтын “угсаатан зүй” гэснийг “угсаатны онцлог” гэж, 3.1.6 дахь дэд заалтын “ашиг, өгөөжтэй” гэснийг “ашигтай” гэж тус тус өөрчилж, 3.1.6 дахь дэд заалтын “эдийн засгийн” гэсний өмнө “нийгэм,” гэж нэмэх. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт.

11-ээс 7 дэмжиж, 63.6 хувиар саналыг дэмжлээ.

8.Төслийн хавсралтын 3.1.3 дахь дэд заалтыг хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт.

11-ээс 7 дэмжиж, 63.6 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн хавсралтад доор дурдсан агуулгатай 4.1, 4.2 дахь заалт нэмэх:

“4.1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 13.2-т заасны дагуу аймаг, сум, дүүргийг өөрчлөх асуудлыг Засгийн газар санаачилна.

4.2.Нэгжгийн өөрчлөлтийн төслийн баримт бичгийг төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, өөрчлөлтөд хамрагдах нэгжгийн Засаг даргын Тамгын газрын төлөөллөөс бүрдсэн Ажлын хэсэг боловсруулна.”. Энэ журмын хамгийн гол амин сүнс заалтуудын нэг нь энэ байгаа юм. Санаачилга нь Засгийн газраас гарч байх тухай асуудал ийм заалт орсон байгаа. Энэ ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт. Тийм, засаг санаачилсан юм.

11-ээс 7 дэмжиж, 63.6 нэмлээ. Тийм тийм. Саяын энэ 9 дүгээр заалт хамгийн гол амин сүнс заалт юм байгаа юм. Орж өөрчлөгдсөн зүйлээс зарчмын зөрүүтэй.

10.Төслийн хавсралтын 4.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 4.4 дэх заалт болгох:

“4.4.Ажлын хэсэг нэгжгийн өөрчлөлтийн төсөл боловсруулахдаа энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан мэдээллийг тусгана.”. Ажлын хэсгийн санал, дэмжье. Санал хураалт.

11-ээс 7 дэмжиж, 63.6 хувиар энэ саналыг дэмжлээ.

11.Төслийн хавсралтын 4.5 дахь заалтыг хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт.

11 гишүүнээс 7 нь буюу 63.6 хувь нь саналыг дэмжлээ.

12.Төслийн хавсралтын 4.1.3 дахь дэд заалтын “хөдөлгөөнийг” гэснийг “хөдөлгөөний хандлагыг” гэж, 4.1.5 дахь дэд заалтын “төрийн” гэснийг “иргэдэд зориулсан төрийн” гэж, мөн дэд заалтын “үйлчилгээ иргэдэд хүртээмжтэй” гэснийг “үйлчилгээний чанар, хүртээмж өмнөх түвшинээс дээшилсэн” гэж тус тус өөрчилж, 4.1 дэх хэсгийн “Засгийн газар, түүний харьяа яам, агентлаг” гэснийг хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт.

11 гишүүнээс 6 нь буюу 54.5 хувь нь саналыг дэмжлээ.

13.Төслийн хавсралтын 5.1 дэх заалтын “үнэлгээ” гэснийг “шинжилгээ” гэж, 5.3 дахь заалтын “дүүргийн хувьд” гэснийг “дүүргийг” гэж, мөн заалтын “аймгийн хувьд” гэснийг “аймгийг” гэж, 5.4 дэх заалтын “асуудлын талаар иргэдээс өөрчлөлтийг “дэмжиж байна”, “дэмжихгүй” гэсэн томъёоллоор санал” гэснийг “асуудлаар иргэдийн саналыг энэ журмын хоёрдугаар хавсралтад заасан саналын хуудсаар” гэж, 5.5 дахь заалтын “сонгуулийн насны иргэдийн олонх оролцсон бол санал авах ажлын дүнг” гэснийг “сонгуулийн эрх бүхий иргэд оролцох бөгөөд олонх нь оролцсон

бол санал хураалтыг” гэж, 5.10 дахь заалтын “хураалтын нэгдсэн дүнг санал хураалтаас хойш” гэснийг “хураалт дууссаны дараа саналын хуудсыг тоолж, дүнг” гэж, 5.11 дэх заалтын “5” гэснийг “3” гэж тус тус өөрчилж, 5.10 дахь заалтын “нэгдсэн” гэснийг хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт.

11 гишүүнээс 6 буюу 54.5хувийн саналыг дэмжлээ. Мөнх-Оргил гишүүн хоцорсон байна.

14.Төслийн хавсралтад доор дурдсан агуулгатай 5.4, 5.5, 5.6 дахь заалт нэмэх:

“5.4.Аймгийг өөрчлөх асуудлаар Засгийн газар энэ журмын 5.3-т заасан хугацаанд багтаан санал хураалт явуулах байршил, өдөр, цагийг товлон зарлана.

5.5.Сум, дүүргийг өөрчлөх асуудлаар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ журмын 5.3-т заасан хугацаанд багтаан санал хураалт явуулах байршил, өдөр, цагийг товлон зарлана.

5.6.Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нэгжгийг өөрчлөх асуудлаар санал хураалтыг урьдчилан тогтоосон байранд, битүүмжилсэн саналын хайрцганд нууцаар авна.”. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт

11 гишүүнээс 7 буюу 63.6 хувь нь энэ саналыг дэмжлээ.

15.Төслийн хавсралтын 5.3 дахь заалтын “арга хэмжээг” гэсний дараа “энэ журмын 4.2-т заасан ажлын хэсэг нэгжгийн өөрчлөлтийн төслийн баримт бичгийг боловсруулан хүлээлгэн өгснөөс хойш” гэж нэмэх гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт.

11 гишүүнээс 7 буюу 63.6 хувийн саналыг дэмжлээ.

16.Төслийн хавсралтын 5.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.7.Өөрчлөлтөд хоёр ба түүнээс олон нэгж хамрагдах тохиолдолд тухайн өөрчлөлтөд хамрагдаж байгаа нэгжүүдийн санал хураалтад оролцсон нийт иргэдийн олонх дэмжсэн саналыг хүчинтэйд тооцно.” гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт.

11-ээс 7 буюу 63.6 хувийн саналаар дэмжлээ.

17.Төслийн хавсралтын 5.8 дахь заалтыг хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт.

11-ээс 7, 63.6 хувиар санал дэмжигдлээ.

18.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжгийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журмын төслийн 1 дүгээр хавсралтын 1.4 дэх мөрний “асуудал” гэсний дараа “/өөрчлөх болсон үндэслэл, шалтгаан/” гэж, 1.5 дахь мөрний “хуваах” гэсний дараа “шилжүүлэх” гэж, 3.1 дэх мөрний “Хучилттай” гэсний өмнө “Хатуу” гэж, 4.2 дахь мөрний “Боловсрол” гэсний дараа “Мэргэжлийн сургалтын байгууллагын тоо, хүчин чадал, хамрагдалт, орон тоо” гэж тус тус нэмэх гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт

11-ээс 7, 63.6 хувиар санал дэмжигдлээ.

19.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжгийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журмын төслийн 1 дүгээр хавсралтын гарчгийн “ТАЛААРХ” гэснийг “ТӨСЛИЙН” гэж, 1.1 дэх мөрний “Харьяалал /аймаг, сум, нийслэл, дүүрэг” гэснийг “Нэгжгийн харьяалал /аймаг, дүүрэг/” гэж, 1.2 дахь мөрний “Тухайн нэгж” гэснийг “Нэгжгийн нэр” гэж тус тус өөрчилж,

2.1 дэх мөрний “/2010, 2020 он/” гэснийг, тайлбар хэсгийг “агентлаг” гэснийг хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт

11-ээс 7 гишүүн 63.6 хувиар саналыг дэмжлээ.

20.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журмын төслийн 2 дугаар хавсралтын “...аймгийн ... сумыг /дүүрэг/” гэснийг “... засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг дэмжье. Санал хураалт.

11-ээс 7. Мөнхцэцэг гишүүнийг дэмжсэнд бүртгээрэй. 63,.6 хувиар санал дэмжигдлээ.

21.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журмын төслийн 2 дугаар хавсралтын “хуваах” гэсний дараа “, шилжүүлэх” гэж тус тус нэмж, “татан буулгах,” гэснийг тус тус хасах. Ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт.

11-ээс 7 гишүүн дэмжиж, 63.6 хувиар санал дэмжигдлээ.

22.Тогтоолын төслийн болон хавсралтын талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, заалт, дэд заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх, агуулгыг алдагдуулахгүйгээр хүснэгтийн загварыг өөрчлөх гэсэн ажлын хэсгийн саналыг дэмжье. Санал хураалт.

11-ээс 7 дэмжиж, 63.6 хувиар санал дэмжигдлээ.

14 дүгээр санал дээр хавсралтад доор дурдсан агуулгатай 5.4, 5.5, 5.6-тай зах заалт нэмэх гэсэн 3 санал байгаа. Энэнийхээ найрлага дээр нь манай ажлын хэсэг, Ганболд гишүүн та нар

анхаарчхаарай. Дараа нь эд нар хэлчих байх.

Ажлын хэсгээс оруулж ирсэн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хурааж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаатараар дамжуулан Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны иргэн Дүүжий гэж хүнээс санал ирсэн байна. Уншиж танилцуулъя. Ганболд дарга хэлээрэй. Энэ ирж байгаа санал бид нарын оруулж байгаа тогтоолын үзэл баримтлал, бусад заалтуудтай зөрөлдөх нь үү, үгүй юү гэж үзээд зөрөлдөнө гэвэл санал хураахгүй явуулж болно, эсвэл хураагаад дэмжигдэхгүй байж болно. Зөрөлдөхгүй гэвэл санал хураагаад үзье.

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны иргэн Дүүжигээс ирүүлсэн.

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн, Их Хурлын дэд дарга Мөнхбаатар зарчмын зөрүүтэй санал болгож оруулж байгаа. Энд журмын Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журмын төсөлтэй танилцлаа. Төслийг ерөнхийд нь дэмжиж байна. Дараах заалтуудыг доорх байдлаар найруулахыг хүсэж байна гэсэн байна. Ганболд гишүүн ээ сонсоорой анхааралтай. Үүнд 5.4 дээр ИТХ нь нэгжийг өөрчлөх асуудлын талаар нэгжийн өөрчлөлтөд хамрагдаж байгаа иргэдээс өөрчлөлтийг дэмжиж байна, дэмжихгүй байна гэсэн томъёоллоор санал авна.

5.5.Санал хураалтад нэгжийн өөрчлөлтөд хамаарагдаж байгаа тухайн нутаг дэвсгэрт байгаа оршин суугаа сонгуулийн насны иргэдийн олонх оролцсон бол санал авах ажлыг хүчинтэйд тооцно.

5.6.Өөрчлөлтөд энэ нэгж хамаарах, 1 нэгж хамаарах тохиолдолд нэгжийн өөрчлөлтөд хамаарагдаж байгаа иргэдийн олонх дэмжсэн саналыг

хүчинтэйд тооцно гэж тус тус найруулах шаардлагатай байна гэж санал ирүүлсэн байна.

Үндсэндээ дандаа бид нарын сая орчихсон саналууд байна гэж бодож байна. Ерөөсөө асуудлаар Засгийн газраас тавиад л иргэдээс асуухдаа энэ саналыг дэмжиж байна уу, үгүй юү гэж хураана. Бусад нь дандаа иргэдийн олонх нь оролцсон бол хүчинтэйд тооцох заалт. Бид нарын сая Байнгын хорооноос оруулсан, ажлын хэсгээс оруулаад сая Их Хурлаар Байнгын хороогоор дэмжигдчихсэн саналууд байна.

Тийм учраас үүнийг заавал санал хурааж шийдэх шаардлагагүй гэж үзэж. Болж байна уу тийм ээ? Тийм, энэ ирсэн саналууд ажлын хэсгээс оруулж ирсэн саналуудтай агуулга, үзэл баримтлалын хувьд нэг байна. Бүгдийг нь санал хураагаад дэмжигдсэн учраас дахин санал хураах шаардлагагүй гэж үзэж байна.

“Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Ганболд танилцуулна.

Төрийн байгуулалтын байнгын хороогоор нэгдүгээр асуудлаа хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа орёё. Ажлын хэсгийнхнийгээ урьчих. Ажлын хэсгийнхэндээ баярлалаа. Доктортоо баярлалаа. Тэр холоос мөн ч олон дахиж ирлээ дээ. Баярлалаа танд. Тийм. Монголд сумын холбогдолтой асуудлыг хамгийн их судалсан, хамгийн сайн мэддэг ийм доктор байгаа манай Жаргал багш. Дараагийн асуудалдаа орёё.

14.46 цаг

Хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн талаарх Төрийн албаны зөвлөлийн 2023 оны тайланг сонсоно.

Хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн талаарх энэ тайланг сонсохдоо Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйл буюу 112.1-д Улсын Их Хурлаар хэлэлцэхээр хуульд тусгайлан заасан тайлан, илтгэл, мэдээллийг эрх бүхий байгууллага хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд ирүүлнэ.

12.2.6-д хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн талаарх Төрийн албаны зөвлөлийн тайланг Төрийн байгуулалтын байнгын хороонд жил бүр, 112.3-д энэ хуулийн 12.2-т заасан тайланг Улсын Их Хурал авснаас хойш ажлын 3 өдрийн дотор Улсын Их Хурлын цахим хуудаст нийтлэх бөгөөд ажлын 10 өдрийн дотор Улсын Их Хурлын Тамгын газар шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороо, гишүүдэд тараасан байна гэж заасан байдаг.

Тайланг Төрийн албаны зөвлөл өнгөрсөн долоо хоногт Монгол Улсын Их Хурлын даргад ерөнхийд нь танилцуулсан. Ингээд Байнгын хороогоор нь хэлэлцэх чиглэлийг нь өгсөн байгаа. Мөн хуульд заасны дагуу Их Хурлын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газраас тайланд шинжилгээ хийгээд, дүнг нь та бүхэн тараасан байгаа.

Өнөөдрийн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн дарга Цэдэвсүрэн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Пүрэвдагва, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Баатарсайхан, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Идэрчулуун, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Амартөгс, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга Жавзан, Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газрын дарга

Сосорбарам? Тэр байна. Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Бат-Эрдэнэ ирсэн байна. Төрийн албаны зөвлөлийн Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын дарга Чинзориг ирсэн байна. Төрийн албаны зөвлөлийн Захиргаа удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Гантулга ирсэн байна. Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Нармандах ирсэн байна. Мөн зөвлөлийн Захиргаа, удирдлагын газрын мэргэжилтэн Сайханаа ирсэн байна. Улсын Их Хурлын Тамгын газрын хяналт шалгалтын газраас холбогдох хүмүүс ирсэн байгаа.

Хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн талаарх Төрийн албаны зөвлөлийн 2023 оны тайлангийн танилцуулгыг Төрийн албаны зөвлөлийн дарга Лхагвын Цэдэвсүрэн хийнэ. Дэлгэрэнгүй тайланг Улсын Их Хурлын гишүүдэд тараасан. Ерөнхий тайланг, товч тайланг Их Хурлын даргад бас танилцуулсан байгаа. Цэдэвсүрэн даргыг урьж байна. 2 номерын микрофоныг өгье. 1 байна уу? 1 номер байна.

Л.Цэдэвсүрэн: Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны 2023 оны болон төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн тайланг хуульд заасны дагуу хугацаанд нь Улсын Их Хуралд хүргүүлж, тайлангаа тавихаар өнөөдөр Төрийн албаны зөвлөлийн баг, гишүүд хүрэлцэн ирээд байна.

Төрийн албаны төлөв байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийг бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, сургалтын хэрэгцээг оновчтой төлөвлөх зорилгоор Монгол Улсын төрийн байгууллага нийт албан хаагчдын тоо, бүртгэлийг Төрийн

албаны хуульд заасны дагуу Төрийн албаны зөвлөл хөтлөх ёстой.

Бид энэ тоо, бүртгэлийг цахим системээр хөтөлж, төрийн байгууллагын цахим системүүдтэй, бусад цахим системүүдтэй интеграци хийх ажлыг жилээс жилд сайжруулж, өргөжүүлсээр ирлээ.

Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо, цахим системд 2023 оны нэгдсэн тоо бүртгэлээр өнөөдөр 2023 оны 12 сарын 31-ний байдлаар нийт 4239 төрийн байгууллагад 226496 албан хаагч ажиллаж байна. Энэ нь 2022 оны тоотой харьцуулбал төрийн албан хаагчдын тоо 0.6 хувиар өссөн ийм үзүүлэлттэй байгаа. Хэдийгээр мэргэжлийн хяналтын байгууллагууд 2023 онд татан буугдсан боловч цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, төрийн болон орон нутгийн бусад байгууллагууд шинээр байгуулагдсантай холбогдуулаад төрийн албан хаагчийн тоо 0.6 хувиар өсжээ. Өсөхдөө улс төрийн албан тушаал, төрийн үйлчилгээний албан тушаал, төрийн тусгай албан тушаал дээр тодорхой хувь хэмжээ өсөөд, төрийн захиргааны албан хаагчдын тоо 1.8 хувиар буурсан ийм тоо бүртгэл та бүхэндээ танилцуулж байна. Нийт төрийн албан хаагчдын маань 7.3 хувь нь удирдах албан тушаалтнууд байна. 78.9 хувь нь гүйцэтгэх, 13.6 хувь нь туслах ажилтнууд.

2022 онтой харьцуулаад үзэхэд туслах ажилтны тоо эрс буусан үзүүлэлт харагдаж байгаа. Энэ нь яагаад вэ гэхээр 2023 онд Засгийн газраас төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын төрлийг шинэчлэхдээ туслах албан тушаалыг хассантай холбогдуулж тоо ийм буурсан үзүүлэлттэй харагдаж байна.

Төрийн албан хаагчийн тоо маань Монгол Улсын нийт хүн амын 6.67 хувийг эзэлж байна. Ер нь 2020 оноос хойших

судалгааг харахаар төрийн албан хаагчдын тоо хүн амд эзлэх хувь нь 6.1-6.7 хувьд хэлбэлздэг юм байна. Нийт Монгол Улсын ажиллах хүчний 18.2 хувийг эзэлж байгаа. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2023 онд зөвлөмж гарсан байдаг. Төрийн албан хаагчийн тоог Монгол Улсын нийт ажиллах хүчний тоотой уялдуулж тогтоох талаар ийм зөвлөмж гаргасан. Энэ ажиллах хүчний тоотой уялдуулна гэж юу байдаг юм бэ гээд судлаад үзэхээр Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн болон түнш орнуудын үзүүлэлтээс үзэхэд энэ харьцаа ер нь 15 хувьтай байдаг юм байна. Монгол Улсынхаа энэ харьцааг 20 оноос хойш судлаад үзэхээр ер нь төрийн албан хаагчийн тоо нийт ажиллах хүчний тоо 16.4-18.2 хувьд хэлбэлзээд байна. Яг 15 гэдэг тоо 2015 онд 15 хувьтай байсан ийм урьд онуудын түүх бас харагдлаа.

Төрийн албан хаагчийн дундаж наслалт залуужиж байна. 2022 онд төрийн албан хаагчийн дундаж наслалт 40.1 сар байсан 40 нас. 23 оны тоо бүртгэлээс үзэхээр энэ маань 38.6 настай болж. Ер нь Монгол Улсын төрийн албан хаагчдын тоо харьцангуй залуужих ийм хандлагатай байна.

Хүйсийн байдлыг аваад үзвэл эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр хэвээрээ л байна. Гэхдээ тодорхой 22 оноос бууралт бас ажиглагдаж байгаа. Тоо баримтыг хараад үзэхээр 67.7 хувь нь эмэгтэйчүүд, 36.3 хувь нь эрэгтэйчүүд байна. Нийт төрийн албан хаагчдын. Өмнөх оны тоо бүртгэлтэйгээ 22 онтой харьцуулаад үзэхээр төрийн тусгай албан дээрх төрийн эмэгтэйчүүдийн тоо хэмжээ бууралттай. Эсрэгээрээ төрийн тусгай болон улс төрд эзэлж байгаа эрэгтэйчүүдийн тоо өсөлттэй байна. Тэгэхээр энэ нь нийт албан тушаалын ангилалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь их юм шиг мөртөөсөө төрийн үйлчилгээ дээр эмэгтэйчүүдийн эзлэх хувь бууралттай ийм хандлага байгаа. Нарийвчилсан судалгаанууд та бүхэнд

тараагдсан материал болон ном дээр байгаа учраас би маш товчхон танилцуулгыг хийж байна.

Төрийн албан хаагчдын боловсролын түвшин өмнөх оныхоос бас харьцуулахад тодорхой өөрчлөлтүүд гарсан байна. 60 гаруй хувь нь магистр болон бакалаврын түвшний албан хаагчид эзэлж байна. Тэгээд харьцангуй бид нар бас төрийн албан хаагчдынхаа байдлыг харахаар албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулж байгаатай холбогдуулаад бас магистрын болон бакалаврын зэрэгтэй албан хаагчдын маань тоо өсөх ийм хандлагатай байна гэж үзсэн. Төрийн албаны хүний нөөцийг бүрдүүлэх, ялангуяа чадахуйн зарчимд суурилсан сонгон шалгаруулалт зохион байгуулах нь манай байгууллагын голлох чиг үүргийн нэг байдаг. 2023 онд энэ төрийн албаны сонгон шалгаруулалттай холбоотой 5 журмыг нэгтгэж, 1 журам болгосон. 2022 онд Төрийн албаны хуульд өөрчлөлт орсноор ерөнхий шалгалтыг жилд 4 удаа авдаг болсон. Ингэж авснаараа бол иргэдэд төрийн албанд орох идэвх, сонирхлыг нь нэмэгдүүлэх, шалгалт хооронд дээ хугацааны уян хатан зохицуулалтыг хангах, ялангуяа төрийн байгууллагуудад үүсээд байгаа энэ сул орон тоог нөхөхөд нэлээн ийм ахицтай зүйл болсон байна гэж бид дүгнэсэн.

2023 онд нийт 4 удаагийн нөөц бүрдүүлэх ерөнхий шалгалтад 12683 хүн орж, үүний 41 хувь нь тэнцсэн. Энэ 41 хүн бүгд төрийн албаны нөөцөд бүртгэгддэг. Гэтэл энэ 41 хувийн маань 38.3 хувь нь л төрийн байгууллагад орсон байна. Тэгэхээр бид нар цаашид нөөцөд байгаа иргэдийг төрийн албанд орох боломжийг нь нээж өгөх ёстой болж байгаа юм. 2023 онд бас манай байгууллагаас хийсэн гол онцлох ажил юу вэ гэхээр хуульд орсон өөрчлөлттэй холбогдуулж энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрийн албанд ажиллах нөхцөл, боломжийг нь нээх зорилгоор хөнгөрүүлсэн босго оноотой шалгалтыг зохион байгуулсан. 2023 онд нийт 14

иргэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн тэнцсэн. Энэ хүмүүсийгээ бас төрийн албанд ажилд оруулах талаар Төрийн албаны зөвлөлөөс энэ үр дүнгээ илүү сайн бодитой болгох арга хэмжээнүүдийг бас төрийн байгууллагуудтайгаа хамтраад авч байна.

2023 онд тусгай шалгалтын зохион байгуулалтууд хийгдсэн. Нийт төрийн байгууллагуудаас Төрийн албаны зөвлөлд хандаж 10372 сул ажлын байрны захиалгуудыг ирүүлсэн. Энэ сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөл болон салбар зөвлөл хамтарч хэрэгжүүлж, 4316 албан тушаалд хамгийн сайн тэнцсэн хамгийн өндөр оноотой иргэдийг нэр дэвшүүлсэн. Энэ хүмүүс маань тухай тухайн албан тушаалдаа ингээд томилогдоод үе шаттай томилогдоод явж байна.

Төрийн үйлчилгээний байгууллагуудын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтын ажлыг бас Төрийн албаны зөвлөл болон салбар зөвлөл хамтарч хэрэгжүүлдэг. 2023 онд 431 албан тушаалын сул орон тоог захиалсны дагуу энэ сонгон шалгаруулалтыг хийж, орон тооны нөхөлтүүдийг нь бас хийгээд явж байна. Харьцангуй энэ тусгай шалгалтын болон төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын тусгай шалгалтын нөөц бол сайн байна. Гэхдээ энэ дээр буцаагаад яг хэрэгжилт ямар байна гэдэг дээр бид нар бас эргэж үзэх тийм хандлагууд гараад байгаа.

Төрийн албаны зөвлөлийн чиг үүргийн бас нэг гол зүйл юу вэ гэхээр бид нар төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийдэг. Өнгөрсөн 2023 онд Төрийн албаны зөвлөл нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, иргэдийн бас өргөдөл, гомдлын дагуу нийт хяналт шалгалтуудыг хийсэн. 267 байгууллагын 4935 төрийн жинхэнэ албан хаагчийг хамруулсан ийм шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтын маань гол юу байдаг вэ гэхээр албан хаагчийг сонгон

шалгаруулж, томилох үйл ажиллагаа яг хууль тогтоомжийн дагуу явсан уу, үгүй юү гэдэг дээр хяналт шалгалт хийж, энэ дээр 476 хууль зөрчсөн томилгооны зөрчил байна гэдгийг тогтоож, холбогдох арга хэмжээг авхуулсан. Хяналт шалгалт хийж байх явцад томилох эрх бүхий этгээд 185 зөрчлийг маш хурдан шуурхай арилгаж, Төрийн албаны зөвлөлтэйгөө хамтарч ажилласан байгаа. Зөрчилтэй томилгоотой 291 шийдвэрийг бас хэрэгжүүлэх тал дээр нь нэлээн анхаарал тавиад ингээд хяналт тавиад ажиллаж байна.

Төрийн албаны хуульд иргэнийг эсвэл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны байгууллага эсвэл шүүх тогтоох юм бол төрд учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нь төлүүлэх гэсэн ийм заалт байдаг. Энийг хэн хэрэгжүүлдэг юм бэ гэхэд Төрийн албаны зөвлөл хэрэгжүүлдэг.

2023 онд бид нар 201 шүүхийн шийдвэрийг албан ёсны бүртгэлд хамруулж, 135 албан тушаалтанд хамрагдах 1.8 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй хохирлыг бүртгэлдээ оруулсан. Энэ хохирлыг буруутай албан тушаалтнаар нь төлүүлэх ажлыг бас хийсэн. Яг шалгалтын явцад 10 албан тушаалтан 103 сая төгрөгийг буцаагаад улсын төсөвт тушааж, зөрчлөө арилгасан. Ерөнхийдөө 2023 онд нийт 253.6 сая төгрөгийг буруутай этгээдээр нь улсын төсөвт буцааж төлүүлэх энэ арга хэмжээг авсан. Үлдсэнийг нь үе шаттай бас төлүүлэх ажлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтраад ингээд зохион байгуулж байна.

Үүнээс гадна Төрийн албаны зөвлөлд төрийн албанд нэр дэвшиж байгаа өөрийнх нь ашиг сонирхол зөрчигдсөн гэсэн ийм маш олон гомдлууд ирдэг. Энэ гомдол болгоныг хянан шалгаж алинд дээр нь яг комисс

ажиллуулах вэ алин дээр нь хариу өгөх вэ гэдэг ийм үе шаттай ажлуудыг зохион байгуулсан. Одоо бид нар 479 гомдлоор 46 маргаан үүсгэж хянасан. Харьцангуй энэ маань 2022 оноос 27 хувиар буурч байгаа нь ер нь Монгол Улсын хэмжээнд төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилт жил бүр сайжраад тодорхой хэмжээний үр нөлөөгөө үзүүлж байна гэсэн ийм дүгнэлтийг бол хийсэн. Төрийн албаны хуульд чадахуйн зарчмын хэрэгжилтийг хүний нөөцийн аудит хийх гэсэн ийм зүйл, заалт байдаг. Энийг манай Төрийн албаны зөвлөл хэрэгжүүлдэг. Хэдийгээр энэ маань шинэ юм шиг боловч бид нар 2023 онд энэ аудитын төлөвлөгөө гэдгийг баталж олон улсын туршлагыг бас нэвтрүүлж, аудитын гарын авлага, аудит хийх ёстой хүмүүсээ бэлтгэх ийм бэлтгэл ажлуудыг нэлээн хийлээ. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар дахь 176 албан хаагчийг хамруулсан хүний нөөцийн аудитыг Монгол Улс анх удаагаа 2023 онд хийсэн.

Цаашид энэ аудитыг илүү өргөжүүлэх, мэргэшсэн энэ албан хаагчдыг бэлтгэх ажлуудыг бас ингээд үргэлжлүүлж хийх ийм төлөвлөлттэй явж байна. Төрийн албаны зөвлөл нь төрийн албан хаагчдын сургалтын агуулга, хөтөлбөр, сургалтыг явуулах төрийн албан хаагчид болон төрийн албатай холбоотой судалгааны ажлуудыг өөрөө бие дааж болон холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтарч хийх ийм чиг үүрэгтэй. Өнгөрсөн хугацаанд бид нар Засгийн газар болон Удирдлагын академитай хамтарч төрийн албан хаагчдыг сургах, багц цагийн мэргэшүүлэх сургалтын агуулга хөтөлбөрүүдийг шинэчилж баталж, нэр бүхий албан хаагчдыг сургалтад үе шаттай хамруулж байна.

Бүх төрийн албан хаагчдаа хүрэхүйц хэмжээний богино хугацааны 7, 4, 10 гэдэг ийм богино хугацааны мэдлэг олгох чадвар, олгох мэдээлэл өгөх зорилготой ийм сургалтыг бас хэвшүүлж чадлаа. Энэ маань бол ёсондоо маш өргөн

хүрээний ийм богино хугацааны сургалтын бас ийм хэв маяг болж байгаа нь талархууштай үйл явдал болсон. Төрийн албаны ялангуяа төрийн захиргааны жинхэнэ албанд ажиллаж байгаа албан хаагчдад зэрэг, дэв олгох асуудлыг Төрийн албаны зөвлөл бас хуулийнхаа хүрээнд хянаж шалгаж Монгол Улсын Ерөнхийлөгч болон Монгол улсын ерөнхий сайдад ханддаг. Үүнийхээ хүрээнд бид нар нийт 236 төрийн албан хаагчдын зэрэг, дэвийн асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдад хандаж өнгөрсөн онд шийдвэрлүүлсэн байна. Хэдийгээр энэ нь ингээд тоо хэмжээний хувьд бага юм шиг харагдавч цар хүрээний хувьд нэлээн далайцтай ийм ажил болж байгаа юм.

Төрийн албаны зөвлөл нь Төрийн албаны хуульд заасны дагуу төрийн байгууллагуудын албан тушаалын ангилал, зэрэглэл болон албан тушаалын тодорхойлолтыг батлах, зөвшөөрлийг хянаж бас өгдөг. Өнгөрсөн хугацаанд албан тушаалын тодорхойлолттой холбоотой маш олон шийдвэрүүдийн төслүүд ирж 2023 онд нийт 1608 албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах эрх бүхий албан тушаалтанд нь хүргүүлсэн байна. Буцаагаад энэ дээрээ бас хяналт тавьдаг. Яг албан тушаалын тодорхойлолтыг хангасан хүмүүс маань ажилд томилогдож байна уу, үгүй юү гэдэг дээр хяналт тавьж ажилладаг байгаа.

Судалгаа шинжилгээний хувьд өнгөрсөн онд Засгийн газарт хэрэгжүүлж байгаа энэ “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд ялангуяа төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд нийт 21 аймаг, 9 дүүргийн 6400 гаруй нийт 29165 албан хаагчдыг хамарсан судалгааны ажлыг хийсэн. Судалгаагаар гол нь төрийн албаны өнөөгийн нөхцөл байдал, төрийн албанд учирч байгаа бэрхшээл, таны өөрийн чинь ажилтай холбоотой бэрхшээлтэй холбоотой ийм судалгааны ажлыг төрийн албаны чанарын ярилцлагын хурдасгуур төвтэй хамтраад

зохион байгуулсан байгаа. Энэ нь тодорхой хэмжээнд үр дүнгээ өгч энэ онд энэ судалгааны үр дүнд суурилсан төрийн албан хаагчдын цалин нийгмийн баталгаатай холбоотой асуудлууд маань үе шаттайгаар хэрэгжээд ингээд явж байна. Түрүүний хэлсэн бид нарын 7, 4, 10 сургалтад ер нь улсын хэмжээнд бид нар 1 удаагийн байдлаар бараг 3 мянган хүнийг хамруулсан ийм сургалт хийдэг. Энэ нь ганц Төрийн албаны зөвлөл хийгээд байгаа гэдгээсээ илүүтэй төрийн бусад байгууллагууд манай энэ сургалтын үйл ажиллагаанд нэлээн сайн хамтарч ажиллаж байгаа.

Төрийн албаны зөвлөл өөрөө 2019 оны 7 дугаар Улсын Их Хурлын 7 дугаар тогтоолын дагуу нийт 56 орон тоотой ажиллаж байна. 2023 оны маань төсөв 3.8 тэрбум төгрөг байсан. Бид нар хуулийн хүрээнд батлагдсан төсвийнхөө дагуу орон тооныхоо хүрээнд үйл ажиллагаагаа явуулаа. Зөвлөл өөрөө тогтмол хуралддаг, тогтмол асуудлуудыг хэлэлцдэг. Зөвлөл 48 удаа хуралдаж нийт 585 тогтоолыг гаргаж, холбогдох байгууллагуудад хүргэсэн байна.

Төрийн албаны хуульд Төрийн албаны зөвлөл бүрэн эрхийнхээ хүрээнд асуудлыг шийдсэн тогтоол гаргана. Тогтоолыг эрх бүхий албан тушаалтан заавал биелүүлнэ гэсэн ийм хуулийн заалттай. Энэ тогтоол гаргаад орхичихгүй тогтоолынхоо хойноос хэрэгжилтийн асуудлыг нь хянаад ингээд явдаг ийм байгууллага байгаа. Өнгөрсөн хугацаанд буюу 2023 онд манай байгууллагад нийт 3417 албан бичиг өргөдөл, гомдлууд ирсэн байна. Өмнөх оных нь тоо баримттай ингээд харьцуулаад үзэхээр албан бичгийнх нь тоо нь бууралттай, өргөдлийнх нь тоо нь өсөлттэй байгаа. Бид нар бас Байнгын хороотойгоо зөвлөлдөж Улсын Их Хурлынхаа бас Хяналт шинжилгээний газрынхантай ч гэсэн зөвлөлдөж, зарим тохиолдолд гомдол болон өргөдөл энэ албан бичигтэй холбоотой асуудлуудыг цаг хугацаанд нь яг хуулийн хүрээнд

бүрэн дүүрэн хариу өгөхөд нэлээн сайн анхаарч ажилласан байгаа.

Зөвлөлөөс 2600 албан бичгийг холбогдох байгууллагуудад бас бие дааж өөрсдөө хүргүүлсэн. Энэ нь өмнөх оноос 7 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа. Бичиг хэргийн эргэлт дээр яагаад ийм өссөн үзүүлэлт гарав гээд дүгнэлт хийгээд үзэхээр Төрийн албаны хуульд орж байгаа нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулж Төрийн албаны зөвлөлийн чиг үүргийн өөрчлөлтүүд бас гараад, энэнтэй холбогдсон зохицуулалтуудыг хуулийн хэрэгжилтийг хангахад манай байгууллага нэлээн сайн анхаарч ажиллалаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Бид Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт, ялангуяа төрийн албатай холбоотой цахим мэдээллийн тоон бүртгэлээ хөтлөх, цахим мэдээллийн сангаа илүү сайжруулах ялангуяа энэ Монгол Улсын нийт цахимтай холбоотой үйл ажиллагааг дэмжих зорилгоор бусад байгууллагуудын их өгөгдлийн сантай үйл ажиллагаагаа нэлээн уялдуулж байна. Энэ маань яг бид нарын энэ бүртгэл мэдээллийн чанарт нэлээн ахицыг гаргасан гэж 2023 онд үнэлж байгаа. Учир юу вэ гэхээр Сангийн яам, Улсын нэгдсэн бүртгэл, Боловсролын мэдээллийн сан, төрийн албаны цалингийн систем, Хур системтэй холбогдоод ингээд явахаар маш олон мэдээллүүд маань цэгцрэх, сайжрах, хоорондоо шэйр хийх ийм боломжууд ихэс сайн гарлаа гэж үзсэн.

Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтын агуулга, сонгон шалгаруулалтын журмыг шинэчилж, ялангуяа энийг цахимжуулсан нь иргэдэд болон шалгалтад оролцож байгаа төрийн байгууллагуудын нэлээн талархлын хүлээсэн ийм арга хэмжээ болсон. Төрийн албаны шалгалтад хөндлөнгийн нөлөөлөл орох маш их багассан байна. Гэхдээ төрийн албаны

шалгалтын энэ өгөгдөл, даалгаврын сангаа илүү баяжуулах нь зүйтэй шүү гэсэн саналыг бид бид нар төрийн байгууллагуудаас бас нэлээн өгч байгаа.

Төрийн албаны тухай хуульд заасны дагуу Төрийн албаны хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулаад бид нар улс төрийн албан тушаалыг дүйцүүлэх, төрийн тусгай болон төрийн үйлчилгээний удирдах албан тушаалыг төрийн захиргааны зохих албан тушаалтай адилтгах энэ дүрэм, журмуудыг 23 онд маш шуурхай баталснаар иргэдийн төрийн албанд үргэлжлүүлж ажиллах, шатлан дэвших, магадгүй нөөцөд бүртгэхтэй холбоотой үйл ажиллагаанууд нэлээн сайжирсан гэж бас дүгнэж байгаа. Энэ нь төрийн албаны ялангуяа шилжилт хөдөлгөөн дээр нэлээн үр дүнгээ өгсөн ийм арга хэмжээ боллоо гэж үзсэн.

Хууль тогтоомжийнхоо хэрэгжилтийн хяналт шалгалтыг сайжруулах ажлыг үе шаттайгаар хийгээд ялангуяа салбар зөвлөлүүдэд чадавхжуулах ажлыг нэлээн сайн зохион байгуулсан. Хууль тогтоомжийн дагуу зөрчилтэй томилгоо өмнөх оноосоо ингээд нэлээн огцом хувьтай буураад байгаа нь энэ төрийн албан хаагчдын маань мэдлэг ялангуяа салбар зөвлөлийн үйл ажиллагаа, салбар зөвлөлийг ахалж байгаа хүмүүсийн мэдлэг сайжирсан энэ талаар хийсэн манай байгууллагын хийж байгаа ажил үр дүнд хүрч байгаа гэж үзэж байна. Төрд учирсан хохирлыг бас буруутай албан тушаалтнаар нь төлүүлэх ажил ингээж эрчимтэй хийгдэж байгаагаар төрийн эрх бүхий албан тушаалтнуудад өөрсдөө ингээд хариуцлага хүлээх, хариуцлагаа мэдрэх, ялангуяа эдийн засгийн ийм хөшүүрэгтэй үр нөлөөтэй арга хэмжээ боллоо гэж үзсэн.

Яагаад гэхээр хууль бус томилгоо болон төрийг хохироох ийм үйл ажиллагаа жилээс жилд багасах ийм хандлага ажиглагдаж байгаа нь бас сайн үр дүн юм болов уу гэсэн ийм бодолтой

байгаа байна. Түрүүн түрүүн хэлсэн Төрийн албаны зөвлөлийн 7, 4, 10 сургалтын хүрээ илүү өргөжиж, энэ чиглэлээр төрийн албан хаагчдад мэдээлэл өгөх төрийн байгууллагуудын тоо, мэдээлэл өгөх албан хаагчдын сонирхол их нэмэгдэж байгаа нь ганцхан үүгээр дамжуулж төрийн алба ажилтай илүүтэй хувь хүнийх нь хандлага, харилцаа, ёс зүйтэй холбоотой мэдээллүүдийг өгч байна. Энэ нь бид нар төрийн албан хаагчдыг ажлын байран дээр нь зайнаас сургах бас тийм хэлбэрийг бий болголоо гэж үзэж байгаа.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль шинээр батлагдаж 2023 онд Төрийн албаны зөвлөлийн дэргэд Ёс зүйн хороо байгуулагдсан. Ёс зүйн хороо маань үйл ажиллагаагаа энэ онд нэлээн идэвхжүүлж байна. 2023 онд хууль хэрэгжүүлэх бэлтгэл ажлаа нэлээн сайн хангасан. Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлийг илрүүлэх, ёс зүйтэй холбоотой соён гэгээрүүлэх үйл ажиллагаануудыг явуулах ийм бэлтгэлүүдийг 23 ондоо нэлээн сайн хангаж ажиллалаа гэж Төрийн албаны зөвлөл өөрсдийгөө үнэлж, дүгнэсэн. Улсын Их Хурлын Хяналт шинжилгээний дүгнэлт яаж гарахыг сайн мэдээгүй байна. Энэ дээр бид нарт бас тодорхой зөвлөгөө, зөвлөмжүүдийг өгөх болов уу гэж бодож байна. Төрийн албаны зөвлөлийн гишүүд болон удирдлагын баг хэлэлцээд Улсын Их Хуралдаа 3 төрлийн саналыг бас тавих нь зөв гэж өнөөдөр ярилцсан. Төрийн албаны хуулийн хэрэгжилтэд хууль тогтоомжийн дагуу бид нар хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Улсын Их Хурал Ерөнхийлөгч, Засгийн газар болон холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах ийм гол чиг үүрэгтэй манай байгууллага.

Өнөөдрийг 2019 оны 1 сарын 1-нээс хойш мөрдөгдөж байгаа Төрийн албаны хуульд өнөөдрийг хүртэл ямарваа нэгэн чиг үүргийн шинжилгээ хийгдээгүй байна. Хуульд нөлөөллийн шинжилгээ хийгдээгүй байна. Нөлөөллийн шинжилгээг яаралтай хийж Төрийн

албаны хуулийг тогтвортой мөрдөх тал дээр нь бас анхаарч болох уу гэсэн ийм саналыг тавьж байгаа. Мөн Улсын Их Хурлаас баталж байгаа 2 журмыг шинэчлэх ажлыг эхлүүлчихсэн. 2 журмын төслөө Улсын Их Хуралдаа өргөн барьж энэ журмын нэмэлт, өөрчлөлтийг оруулах нь зүйтэй юм болов уу гэж үзсэн.

Төрийн албаны хуулийг тогтвортой мөрдүүлэх гэдэг дээр 2019 оноос хойш өнөөдрийг болтол төрийн албаны хуульд 23 удаагийн өөрчлөлт орсон байна. Энэ өөрчлөлт болгоны цаана манай байгууллагын үйл ажиллагаа дандаа хөндөгдөөд байна. Тэгэхээр бид нар энэ магадгүй энэ хурдыг заримдаа гүйцэхгүй байх тохиолдол гарч байна. Гэхдээ үйл ажиллагааны тогтвортой байдлыг ялангуяа төрийн албаны тогтвортой байдлыг хангахад төрийн албаны хуулийн өөрчлөлтийг бас энэ дүн шинжилгээ дээр нь үндэслээд хий хийдэг зүгээр юм болов уу гэсэн ийм саналууд гарч байгаа. Төрийн албан хаагчийн сонгон шалгаруулах үйл ажиллагааг бид нар энэ олон улсын жишигт нийцүүлэх ялангуяа тухайн хүний өөрийнх нь мэдлэг, ур чадварыг бүрэн илэрхийлэх хэмжээний ийм сорил даалгаврыг хийх талаар Канад, Солонгос, Герман гэсэн улсуудтай нэлээн холбогдож ажиллаж байна. Тестийн сангийнх нь баяжилтуудыг бас сонирхож байгаа. Бид нар өөрсдөө яг Төрийн албаны зөвлөлийн тестийн сангаа бие дааж хийх боломжгүй ийм байгууллага.

Тийм учраас бид нар бага хэмжээний баяжилтуудыг ихэвчлэн захиалгын үндсэн дээр зөвлөх үйлчилгээ авч, Удирдлагын академийн эрдэмтэн багш нарын хүчээр бараг хийж байна л даа. Тэгэхээр энэ улсуудын туршилагыг ингээд үзээд судлаад байхаар биеэ даасан тийм нэгж ажилладаг юм байна. Хараат бус тестийн төв тестийг боловсруулдаг. Тэгэхээр энэ дээр ур чадварын үнэлгээний төв байгуулах боломж байгаа болов уу. Энэ дээр байгууллагыг манай байгууллагыг

дэмжих боломж бас байна уу гэдгийгээ Их Хуралдаа бас Байнгын хороондоо танилцуулж байгаа юм. Төрийн бүтээмж, цахимжуулалтын бодлого, үйл ажиллагаатай уялдуулаад манай байгууллагын дэргэд 2019 оны Улсын Их Хурлын тогтоолоор байгуулсан судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгж гэж Төрийн албаны зөвлөлийн дэргэд байгуулах ёстой ийм нэгж юм байна.

Гэтэл энэ нэгж маань ажлын албаныхаа дотор юм шиг гадна ч юм шиг ингээд тогтоолтойгоо зөрчилдөөд байгуулагдчихсан. Бүтэц орон тоо гэж байхгүй. Өмнө 19 онд баталсан Ажлын албаны 54 орон тооноосоо энэ нэгжээ ингээд ажиллуулаад явж байгаа нь бас зөв шийдэл биш байна. Тийм учраас энэ Их Хурлынхаа тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ажлын албаны бүтцийг үүнийгээ яг ажлын албаныхаа бүтцэд нь оруулъя, дуусаж байна одоо. Ажлын албаныхаа бүтцэд оруулах ийм саналыг та бүхэндээ тавьж байна.

Ингээд Төрийн албаны төлөвшил, хөгжлийн өнөөгийн байдал, чадахуйн зарчмын хэрэгжилт болон төрийн албан хаагчийн сахилга, хариуцлага, ёс зүй, сургалт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр бид 23 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа маш товч танилцуулгыг та бүхэнд танилцууллаа.

Байнгын хорооны дарга болон эрхэм гишүүддээ баярлалаа.

Н.Энхболд: Баярлалаа Цэдэвсүрэн даргад.

Хуулийн дагуу энэ манай Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газраас бас тодорхой хэмжээгээр шалгалт хийж, дүн шинжилгээ хийсэн байгаа. Энэ талаар Ганболд дарга Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын дарга Ганболд товчхон, гол зөвлөмж, анхаарах асуудлуудаа танилцуулчихъя. Хоёрдугаар микрофон өгөөрэй.

С.Ганболд: Төрийн байгуулалтын Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд та бүхэнд өдрийн амгалан ирж мэндчилье.

Их Хурлын Тамгын газраас Төрийн албаны зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээний танилцуулгыг Байнгын хорооны гишүүд та бүхэнд урьдчилан тараасан байгаа. Тийм учраас та бүхэн эдгээртэй танилцсан байх гэж бодож байн. Ингээд Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16.2-т заасны дагуу баримт бичгийн болон статистик шинжилгээний аргыг Их Хурлын Тамгын газар ашиглан бол шинжилгээ хийсэн байгаа. Тамгын газраас өгч байгаа зөвлөмжийг товчхон танилцуулчихъя.

Шинжилгээ Тамгын газраас үйл ажиллагааны шинжилгээнд хийсэн үр дүнд тулгуурлан Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, түүний үр дүнг дээшлүүлэх үйл ажиллагааны эрсдэлийг бууруулахад чиглэсэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд

Нэгдүгээрт, Цаашид тайлангийн агуулгыг боловсруулахдаа Их Хурлын тухай хуулийн Хяналт шалгалтын тухай хуульд заасан хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлэн ажилласан талаар нарийвчилсан тодорхой үр дүн, шинжилгээ бүхий мэдээллийг тусгаж байх.

Хяналт шалгалтын хүрээнд гарсан зөрчил, дутагдлын шалтгаан, нөхцөл, нөлөөлөл, үр дагаварт дүн шинжилгээ хийх. Энэ ажлын дүнг тайланд тодорхой тусгаж байх.

Эрх бүхий албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах. Энэ хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээний мэдээ мэдээллээр Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийг шуурхай хангах зорилго бүхий мэдээлэл,

мэдээлэл дамжуулах, хүлээн авах тогтолцоог бий болгоход чиглэсэн арга хэмжээ авч, үр дүнг тайлагнаж байх.

Төрийн албаны төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулах чиглэлээр арга хэмжээ авч, үр дүнг тус тайланд тусгайлан сэдэв болгон тусгаж хэвиших.

Тавдугаарт, Төрийн албаны зөвлөлөөс төрийн албан хаагчийн ёс зүй харилцаа, хандлага, ажлын байранд баримтлах соёлыг төлөвшүүлэн хэвшүүлэх чиглэлээр соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, хэлэлцүүлэг тогтмол зохион байгуулж байгаа хэдий ч төрийн албаны шинэчлэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үр дүнд суурилсан судалгаа шинжилгээ хийж, үйл ажиллагаандаа үнэлэлт дүгнэлт өгч, тайланд тусгах.

Сургалт, хэлэлцүүлэг, зөвлөн туслах, туслах үйл ажиллагаа болон бусад зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилт, түүний үр дүнд тодорхой, тухай бүр дүн шинжилгээ хийж, дүнг тайланд тодорхой тусгаж байх. Орон нутагт төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний чухал шаардлагатай мэргэжлийн зарим албан тушаалд ажиллах. Хүний нөөцийн хомсдол үүсэж албан тушаалын сул орон тоо нөхөгдөхгүй байдал хэвээр байгаад анхаарч энэ талаар зохих судалгаа шинжилгээ хийх, мэргэжлийн хүний нөөцийн нөөцийг бүрдүүлэх, оновчтой бүтцийг тогтоох ажлыг үе шаттай эхлүүлж зохион байгуулах.

8.Зөвлөл нь Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 61.1.8-д заасан төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулах чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэн ажиллах шаардлага хэвээр байна.

9. Албан тушаалын сул орон тоо хангалттай хэмжээнд нөхөгдөхгүй байгааг анхаарч, үр дүн бүхий арга хэмжээг авч, хэрэгжилтийн явц, үр дүнд шинжилгээ хий тайлагнадаг байх.

10. Төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд илэрсэн нийт зөрчлийн 72.5 хувийг 11 аймаг, үүний дараа 111 буюу 24.6 хувийг Нийслэл Улаанбаатар хотын 4 дүүрэгт хийгдсэн хяналт шалгалтын үеэр илэрсэн байгаагаа анхаарч зөрчлийг дахин давтагдахгүй байхад чиглэсэн үр дүн бүхий арга хэмжээ зохион байгуулж, үр дүнг тайлагнан ажиллах шаардлагатай байна гэсэн ийм зөвлөмжийг өгч байна.

Н.Энхболд: Баярлалаа. Төрийн албаны зөвлөлийн тайлан, түүнд хийсэн Тамгын газрын шинжилгээний дүнгийн талаар танилцууллаа холбогдох дарга нар.

Одоо саяын тайлан, шинжилгээний дүн, илтгэлтэй холбогдуулаад асуулт асуух, үг хэлэх гишүүд нэрээ өгье. Хамт явна шүү.

Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Тэгэхээр энэ Төрийн албаны зөвлөлийн эрхэм гишүүд ажлын албаныханд бас хүрэлцэн ирсэн явдалд баярлалаа. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн ажлын хэсгийн ахлагчаар би ажилласан. Тэгэхээр парламентын хяналт шалгалтын гол функцийн нэг чухал хэсэг нь манай Улсын Их Хурлын, заримыг нь харьяа гээд байдаг. Тэгэхдээ барууны орнуудад индипендент эженси /indefendent agency/ буюу хараат бус бие даасан ийм Засгийн газрын бус байгууллагууд.

Тэгэхээр энэ дээр парламентын тавих хяналт их өндөр байх ёстой. Бид их олон удаа ярьсан. Энэ хууль маань ингээд хэрэгжээд эхэлж байгаа. Үүний

дагуу ч гэсэн манай Тамгын газар дүн шинжилгээ хийж байна. Сая Ганболд дарга хэлж байна. Мөн Төрийн албаны зөвлөлийнхөн ч гэсэн сая танилцуулгаа ингээд хийгээд явж байна. Энэ бол сайн. Ер нь Их Хурал цаашидаа сонгуулийн жил болчихсон учраас ингээд байна. Ер нь жоохон формалддаг, хэлбэрддэг энэ байдлаасаа илүүтэй Улсын Их Хурал яг ийм тусгайлаад ялангуяа энэ Монгол Улсын хүний нөөцийн чадавхтай холбоотой том асуудлыг парламент авч хэлэлцэж байна шүү дээ. Тэгэхээр энэ бол өргөн олон түмний анхаарал дунд уг нь явагдах ёстой л ийм л эд юм байгаа.

Би яах вэ олон юм яривал энэ олон цагийн ажил. Уг нь нухацтай хийх ажлууд. Гэхдээ хэд хэдэн тодорхой асуултуудыг өөртөө болон энэ иргэд, иргэдийн бас сонирхож байгаа асуудлууд байдаг учраас зарим асуултуудыг энэ завшааныг ашиглаад ашиг асууя гэж бодож байна.

Нэгдүгээрт, Бидний хувьд мэдээж ахиц дэвшилүүдийн тухай дурдаж байна, бас тодорхойгүй асуудлууд байгаа тухай дурдаж байна. Төрийн албаны зөвлөлийн маань Цэдэвсүрэн дарга маань ч гэсэн бас ингээд тодорхой саналууд бас дэвшүүлж байна. Манай төрийн албыг чинь ингээд том, нүсэр байна, улам нэмэгдэж байна гээд байдаг. Тэгэхээр энэ олон янзын шалтгаан байдаг. Заримыг нь нэмж ангилалд хамруулсан ч юм бий, тэгээд зарим нь ч тэртээ тэргүй зүй ёсоороо үйлчилгээний салбарт хүний орон тоо нэмэгддэг ч гэдэг юм уу ингээд ярьдаг байсан. Ямар ч байсан 23 оны тайлан тоонд 226496 төрийн албан хаагч байна гэж байна. Мөн онд 25816 төрийн албан хаагч чөлөөлөгдсөн буюу нийт нэ чинь төрийн албан хаагчдын 11 хувь нь чөлөөлөгдчихөж байна шүү дээ. Энэ хэвийн зүйл үү? Ер нь урьд онуудтай харьцуулбал ямар вэ? КОВИД-ын өмнөх гэдэг юм уу даа. Энэ ямар байж болох вэ? Энэ чинь 10 төрийн албан хаагч тутмын нэг нь л гараад явчхаад байна

шүү дээ ийм байна. Үүний үндсэн асуудал дээр харьцуулагдах маягаар хэлэх арга юу байна?

Хоёрдугаарт, мэдээж төрийн албанд бид нар жендерийн асуудал дээр их онцгой анхаардаг болсон. Би ч гэсэн одоо тэр бүлгийн энэ тэргүүлээд ахлаад энэ парламентад бас сүүлийн 1, 2 жил ажиллалаа. 144183 төрийн албан хаагч буюу 63.7 хувь нь эмэгтэй гэж байна. Тэгэхдээ дотроо удирдах албан тушаалууд, тодорхой ангилал дээр бол эмэгтэйчүүдийн эзлэх хувь харилцан адилгүй байна л даа. Тэгэхээр энэ дээр удирдах албан тушаалд яг ерөнхийдөө эмэгтэйчүүдийн юм ямар юу байна? Үүнийг бас хүмүүс харж байгаа? Тэрнээсээ эмэгтэйчүүд зонхилж байна уу, зонхилж байна. Гэхдээ одоо асуудал юундаа байна вэ гэхээр удирдах түвшин нь ямар байгаа юм бэ гэдэг асуудал байгаа юм.

Энэнтэй уялдуулаад бас гурав дахь асуулт нь бол баг, хорооны Засаг дарга нарын асуудал байж байгаа. 23.7 хувь нь эмэгтэй гэж байна. Тэгэхээр сая бид нар Нэгжийн хуулийн бас би ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж, батлуулсан юм. Энэ Их Хурлын том хууль л даа. Энэ дээр яригдсан юм нь баг, хорооны засаг дарга нараа л ер нь жоохон дээд боловсролтой болгоё. 24 оноос ингээд сонгууль хийгээд явахад дээд боловсролын шаардлага тавья гэсэн. Гэтэл сүүлд энийг чинь хэрэгжүүлэхэд хэцүү юм биш үү гээд аль 2 жилийн өмнө ярьж байсан юмыг сүүлийн үед яриад л байгаа. Баг, хорооны Засаг даргын дээд боловсролын байдал яг ямар байна вэ? Дээд боловсролын байдал? Энэ чинь 60, 70 хувь нь бараг дээд боловсролгүй юм яригдаад л байсан сүүлд 50 хувь гээд л яригдаад байсан. Яг тоочны тодорхой тоон статистик хэлээд ч манай хороодын Засаг дарга нар дотор дээд боловсролын байдал нь ямар байгаа юм нийслэлийн хэмжээнд? Багийн дарга нарын дээд боловсролын байдал үнэхээр ямар байгаа юм? Энэ асуудал байж байна. Ер нь энэ би энэ.../минут дуусав./

Н.Энхболд: Сүхбаатар гишүүний микрофоныг нээчих, үргэлжлүүлээд яваг.

Ж.Сүхбаатар: Тийм. Тэгэхээр энэ баг хорооны Засаг дарга нар гэснээс гадна энэ ерөөсөө энэ сая Засгийн газарт би ажиллаж үзэхэд бол нэг л юм харагдлаа. Ерөөсөө Монголын зовлон бол Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ бол хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлүүдийн асуудлыг яриад Боомтын сэргэлт, Төрийн бүтээмжийн сэргэлт, Ногоон хөгжлийн сэргэлт гэдэг юм уу ингээд олон юм явж байгаа. Энэ дотроо тэр төрийн бүтээмжийн асуудал дотор тэр ялт ч үгүй энэ хүний нөөцийн удирдлагын асуудал, боловсон хүчний асуудал их хүнд юм байна. Нэг бодлого бид нар зөв гаргачихдаг. Гүйцэтгэлийн шатад өнөөдөр үнэхээр тэр агентлаг байна уу, яам байна уу, ялангуяа нийслэл байна уу, тэр аймаг байна уу энэ түвшинд чинь хүмүүс байхгүй шүү дээ. Гүйцэтгэл хийх чадвартай биш. Тэгэхээр энэ хүний нөөцийн удирдлагын асуудал дээр дүгнэлт яаж хийж байгаа энийг Төрийн албаны зөвлөл дандаа хариуцаж чадахгүй шүү дээ. Мэргэжил арга зүйн удирдлага стандартын удирдлагаар л хангана. Стандартын удирдлага гэдэг чинь дүрэм журмуудаа тогтоож стандартаа тавьж өгнө. Засгийн газарт тэр Удирдлагын академийг нь сайжруулдаг байна уу.../минут дуусав./

Н.Энхболд: Энэ микрофоноо нээлттэй орхичихгүй яасан юм? Асуултаа дуусгачих Сүхээ гишүүн. Сүхбаатар гишүүнийхийг өгөөдөх. Тэгээд цаггүй өгчихөөрөө.

Ж.Сүхбаатар: Олон гишүүн асуухгүй байгаа учраас өмнөөс нь асуучхаж байна тийм ээ? Тэгэхээр энэ асуудал дээр юу болж байна? Яг өнөөдөр Ерөнхий сайд ч гэсэн бид нар ингээд л хүмүүстэй уулзаад л ингээд ярихад бүх түвшинд ажил хийх чадвартай хүн байхгүй болчихсон байна шүү дээ. Яг үнэндээ сайхан томьёоллууд гарч байна уу? Гарч байна, бодлого гарч байна уу?

Гарч байна. Нэг үеэ бодвол боловсролтой, чадвартай хүмүүс нэмэгдсэн гээд шийдвэр гаргах түвшинд томъёоллууд хийж чаддаг болчихно. Миний мэдэхийн 20-иод жилийн өмнө, 10 гаруй жилийн өмнө бодлогын тодорхой томъёоллууд муу хийгддэг байсан юм. Тийм учраас шийдвэр гаргах түвшний ажил муу учраас гүйцэтгэл муу байна гэж ярьдаг байсан. Одоо бол тодорхой хэмжээнд бас ч гэж өмнөхтэйгөө харьцуулбал бодлого нь томъёологдоод гараад байдаг, гүйцэтгэл байхгүй.

Тэгэхээр энэ асуудал дээр энэ хүний нөөцийн удирдлагын зохион байгуулалт дээр Төрийн албаны зөвлөл энэ Засгийн газартай хуваалцан хэрэгжүүлэх гэдэг юм уу, хамтран ажиллах чиг үүргийг бодмоор юм байна лээ. Цэдэвсүрэн дарга өөрөө Засгийн газарт, яаманд ажиллаж байсан хүн зааглаж ялгах хэрэгтэй. Тэгэхгүй нэг нэг рүү нь шиддэг биш. Тэгэхээр Засгийн газрын үүрэг ролийг энэ дээр яаж сайжруулах талаар дүгнэлт хийж байгаа вэ?

Дөрөвт нь хүчирхийллийн асуудал их яригдаж байгаа. Би энэ тайлан дээр бол нарийн яасангүй. Ёс зүйн зөрчлүүд бас өндөр хэмжээтэй зөрчил дээр эзэлж байгаа гэж байна. Гэхдээ төрийн албанд хүчирхийлэл хүмүүс чинь жигшээд байна шүү дээ. Янз бүрийн төрийн албан хаагч нар ажлын байран дээр дарамт үзүүлж байна, хүчирхийлж байна гээд байдаг. Энэ асуудал дээрээ бас Төрийн албаны зөвлөл маань нийгэм чинь энэ тайланг чинь ганцхан бидэнд сонсох биш, энэ 23 онжингоо л хүчирхийлэл ярьцаалаа шүү дээ. Тэгэхээр чинь энэ асуудал жендер гэж яригдаад байгаа үндсэн сэдэв яригдаад байна. Тэр хүчирхийллийн асуудал гэж яригдаад байна. Боловсон хүчний чадавхын асуудал чинь чадах уу гэж яриад байна. Чаддаггүй гарууд нь л төрд эзэлчхээд байна гээд байна шүү дээ. Мэргэжлийнхэн биш зарим нь жигшээд намчид, цүнхчид гэж яриад байгаа нь гол нь тэр нь болохоор юу гэж хэлээд байгаа юм гэхээр зэрэг би чадна гээд идэвхтэй

гарууд, тэгсэн хэр нь төрд ингээд шигдчихээд яг чаддаггүй ийм улсууд чинь энэ асуудал байгаа юм. Тэгэхээр энэ хүчирхийлэлтэй холбоотой асуудал дээр Төрийн албаны зөвлөл бас мэргэжил, арга зүй, стандартын удирдлага явуулдаг байгууллагын хувьд бол энэ дээр бас анхаарал яаж хандуулж байна гэдэг ёс зүйтэйгээ холбоод ингээд нэг ийм асуудал байж байгаа юм.

Сүүлд нь манай Тамгын газрын хяналт шалгалтын хэлтэс сул орон тоо 6056 орон тоо нөхөгдөхгүй байгаа шалтгаан нөхцөлд дүн тайлан тодорхойгүй байна гээд бас дүгнэчихсэн байж байна шүү дээ. Энэ дээрт эгвэл амаараа энд яаж дүгнэж байгаа юм бэ гэдгийг нь? Цэдэвсүрэн дарга томилогдоод удаагүй байж болно. Тэгэхдээ энэ Идэрээ гишүүн ирчихсэн байж байна. Сул орон тоо чинь нөхөгдөхгүй байна гээд байна шүү дээ. Гэтэл төрийн албаны юмыг сонирхохгүй байгаа юм уу, чадвар нь хүрэхгүй байгаа юм уу? Шалгалт шалгалтдаа тэнцэхгүй байгаа юм уу, эсвэл та нар шалгалтыг нь хүнд аваад байгаа юм уу? Үнэхээр яагаад сул орон тоо нь нөхөгддөггүй юм? Ажилгүй хүмүүс бас байгаад л байдаг. Төрийн албанд уг нь орох гээд л олон хүн л орох гээд л байх шиг байдаг юм шүү дээ. Энэ дотор эсвэл хаана нь сул орон тоо нь байгаад, илүү их байгаад нөхөгдөхгүй байгаад байгаа юм гэдэг ийм асуудал байгаа юм. 6 мянга гэгчихсэн байна. Ийм хэдэн зүйлүүдийг ямар ч байсан ингээд түүж аваад асууя.

Ер нь цогцоороо ярих асуудлууд байгаа. Чуулганы хуралдаан дээр ч гэсэн гишүүн д асуух байх. Магадгүй тэр дээр бас нэмээд асуух ийм боломж гарах байх гэж бодож байна. Баярлалаа.

Н.Энхболд: Би бас 1, 2, 3 асуулт асууна. Тэгэхээр нэг нь яг Сүхбаатар гишүүнийхтэй давхацчихлаа. Тэгэхээр тэн дээр бас өгчхөөрэй. Тэр нь юу вэ гэхээр яг сая сул орон тоо байна гээд байдаг тэнд хүн ирдэггүй. Тэгэхээр хэд хэдэн шалтгаан байх шиг байгаа юм.

Хүсэхгүй байна уу, цалин хангамж нь дутуу байна уу? Эс үгүй бол шалгуур өндөр байна уу? Тэн дээр ямар дүгнэлтүүд хийж байгаа вэ? Миний нэг асуулт давхцаж байгаа учраас санал асууж, дараа нь хоёрхон асуулт бий. Хэн эхлэх вэ? 1 номер Цэдэвсүрэн дарга.

Л.Цэдэвсүрэн: Сүхбаатар гишүүний асуултад хариулъя. Манай зөвлөлийн гишүүд бас хариулна.

2022 оны тоотой харьцуулбал 2023 онд төрийн албан хаагчдын тоо өссөн юм шиг боловч тодорхой хэмжээний бууралтууд бас ялангуяа төрийн захиргаан дээр ажиглагдсан 1.8 хувийн бууралт. Энийг судлаад үзсэн л дээ. Хүмүүсийг ажлаас чөлөөлөгдсөн гэдгээсээ илүүтэй буцаагаад нөхөлтүүд нэлээн хийгдээд явж байна. Явж байна. Ер нь төрийн улс төрийн албан тушаалын албан хаагчдын тоо 3.6 хувиар өсчихсөн байх жишээний. Төрийн тусгай албан тушаалын албан хаагчдын тоо 1 хувиар, төрийн үйлчилгээний албан тушаалын албан хаагчдын тоо 0.7 хувиар ингээд өссөн ийм тоон үзүүлэлтүүд байгаа юм. Тэгээд Төрийн албаны хуульд жишээ нь орж байгаа өөрчлөлттэй холбогдуулаад магадгүй улс төрийн албан тушаалтны тоо яагаад өсчхөв гэхээр зарим албан тушаал, улс төрийн албан тушаал руу шилжих ийм хандлагууд бас гараад байна.

Тэгэхээр 2022 оны тооноосоо халалт, солилт гэдгээсээ илүүтэй өсөлт бууралт нь хаанаа байв. Яагаад тийм өсөлт болчхов гээд та түрүүн асуусан. Яагаад энэ төрийн үйлчилгээний албаных юу чинь 27 мянга гаруйгаар ингээд буураад байгаа юм бэ гээд. Түрүүн би бас тайлбарласан. 2023 онд Засгийн газар төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын ангилал төрлийг шинэчилж, өөрчлөхдөө туслах албан тушаал гэдгийг бүүр байхгүй болгочихсон. Тэгэхээр энэ нь ингээд бүр бүгдээрээ ингээд байхгүй ажлаас халагдчихсан юм шиг харагдаад байгаа боловч энэ нь буцаад гүйцэтгэх дээрээ

нэмэгдээд ороод ирчихсэн байх жишээний ийм нэг хандлага байгаа.

Удирдах албан тушаалтны хувьд Монголд 2023 оны жилийн эцсийн байдлаар 144183 удирдах албан тушаалтан ажиллаж байсан. Энэ тоо мэдээж өнөөдөр өөрчлөгдөж байгаа. Үүний 7045 нь эмэгтэй хүн байна. Эмэгтэйчүүд удирдах албан тушаалд. 42.43 хувийг эзэлж байна л даа. Тэгэхээр энэ удирдах албан тушаалтнуудын дийлэнх нь хаана байна вэ гээд үзэхэд төрийн үйлчилгээ дээр бас нэлээн их ажиглагдаж байгаа ийм хандлага байна. Баг хорооны Засаг даргын дээд боловсролтой холбоотойг Амартөгс гишүүн, Ёс зүйтэй холбоотойг болон сул орон тоо нөхөгдөхгүй байна гээд түрүүн 4316 албан тушаалд бид нар сул орон тоо гоо ингээд нөх, энэ хүн шалгалтад тэнцлээ гээд өгчхөж байгаа юм хүмүүс.

Энхболд даргын бас асуулт дээр давхар хариулахад албан тушаалд тавигдаж байгаа шаардлагыг хангахгүй тохиолдлууд бас их байна. Энийг хангуулахын төлөө төрийн үйлчилгээг, төрийн захиргаатай адилтгах улс төрийн албан тушаалд ажиллаж байгаа, ажиллаж байсан хүмүүсийг төрийн захиргаа руу дүйцүүлэхтэй холбоотой шийдвэрүүдийг 2023 онд бас нэлээн сайн гаргасан. Энэ маань нэлээн ахиц дэвшил үзүүлсэн гэж бас бодоод байна л даа.

Сонгон шалгаруулалтын маань үйл явц бас тодорхой хэмжээнд хүчингүй болох тохиолдол бас гараад ирдэг, нөхөгдөхгүй байгаагийн 3 дахь гол шалтгаан юу вэ гэхээр томилохгүй байна. Өгдөг сонгон шалгаруулаад май энэ хүн ингээд тэнцчихлээ ингээд өгдөг. Буцаагаад томилгоонууд хийгдэхгүй ийм удааширалтай байдлууд бас нэлээн харагдаад байна. Энэ дээр та нэмж ярих юм уу? Бид нар 2023 онд түрүүн яах вэ тайланг товч гэсэн учраас хэлээгүй. Тусгай тийм захиалгат шалгалтыг бас явуулж үзсэн. Мал эмнэлэг болон байгаль хамгаалагч нар дээр тусгайлсан улсын хэмжээнд энэ хүмүүсийг аль болох л

төрийн захиргааны албан тушаал руу оруулах ийм захиалгуудыг хийж явсан. Энэ нь бас нөлөөллөө үзүүлсэн гэж бодож байгаа. Амартөгс гишүүн.

Н.Энхболд: 2 номер дээр очоод суучих Амартөгс гишүүнээ. Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ёс зүйн хорооны дарга Амартөгс.

Ц.Амартөгс: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Сүхбаатар гишүүний асуусан асуултад зарим тодруулга мэдээлэл өгье. Жендерийн асуудалтай холбоотой асуудал дээр нэмэх нь төрийн албанд ажиллаж байгаа нийт албан хаагчдын дундаж 63.7 хувь байгаа гэсэн. Энэ ялгаатай байдал нь ялангуяа энэ төрийн үйлчилгээний албан дээр 75 орчим хувь нь эмэгтэйчүүд байх байдал ажиглагдаж байна. Удирдах албан тушаалын хувь хэмжээг сая Цэдэвсүрэн дарга тодруулсан. Байгууллагуудын хувьд энэ бас ялгаатай байдал нь харьцангуй өмнөх онтойгоо харьцуулахад огцом өөрчлөлт ажиглагдахгүй байна гэсэн ийм дүн харагдаж байна. Хүйсийн хувьд гэхээс илүү насны хувьд бас энэ хүйсийн байдал нь насны бүлгээр авч үзсэн 35 хүртэлх насны төрийн албанд ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь нь дундаж 63.7-гоос тодорхой хэмжээгээр их байна. Энийг одоо орж ирж байгаа болон төгсөж байгаа, шинээр төрийн албанд орж байгаа албан хаагчдын тоотой уялдуулж авч үзэж болно гэж үзэж байгаа.

Нийт төрийн албан хаагчдын боловсролын үзүүлэлт харьцангуй өөрчлөлт орсон гэж танилцуулга дээр дурдагдсан байгаа. Тэгэхээр 2022 оноос 23 оныг харьцуулах юм бол дээд болон бакалавраас дээш боловсролтой албан хаагчдын тоо хувь хэмжээ нэмэгдсэн. Ялангуяа энэ үзүүлэлтийг сая асуусан асуулттай баг, хорооны Засаг даргын хувьд боловсролын түвшин бол дундаж, дипломын дээд мэргэжлийн болон техникийн боловсролын дээр эзлэх хувь хэмжээ нь дийлэнх буюу 50-аас дээш хувьтай үзүүлэлттэй байгаа.

Нийт 226496 албан хаагчдынхаа хувьд боловсролын хувь хэмжээг авч дийлэнх хувь хэмжээ нь дипломын дээд, бакалавр, магистр байгаа. Докторын түвшиний мэргэжилтэй ажиллаж байгаа хувь хэмжээ бол буурч байна гэсэн ийм үзүүлэлттэй байгаа юм.

Төрийн албанаас гарч байгаа чөлөөлөгдсөнтэй холбоотой мэдээлэл дээр нэмэлт мэдээлэл хийе. Ойролцоогоор 25203 албан хаагч тухайн жилд төрийн албанаас чөлөөлөгдсөн байгаа. Энэ нь ойролцоогоор 10 орчим хувь байна. Энэ 10 орчим хувь нь бол өөрчлөлт хөдөлгөөн нь нэгдүгээрт төрийн алба хаах хугацаанд насны дээд хязгаарт хүрсэн, тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан, мөн бусад байгууллагуудад шилжин ажиллаж байгаа гэсэн. Энэ хөдөлгөөн бүгдээрээ орж байгаа учраас энэ 25 мянга нь ойролцоогоор 10 орчим хувийн хөдөлгөөн байна гэсэн ийм дүн байгаа.

Тэгэхээр энэ бол харьцангуй өндөр гэж тооцохгүй. Харин бид хийсэн яг төрийн захиргааны албан хаагчдын дунд сүүлийн 3 жилийн үзүүлэлтэд хийсэн дүн шинжилгээг харах юм бол энэ яг тухайн албан тушаал дээрээ ажиллаж байгаа байдал нь хөдөлгөөн нь 20 орчим хувь байна гэсэн ийм үзүүлэлт гарсан. Энэ бол бусад улс орны гэдэг юм уу гадаадын зарим улсуудын судалгаатай харьцуулахад өндөр үзүүлэлт байна гэж үзсэн бөгөөд тогтвортой ажиллуулах, төрийн албанд тогтвортой ажиллуулах тал дээр хүний нөөцийн бодлогыг чиглүүлэх ёстой юм гэсэн ийм дүгнэлт гаргаж байгаа.

Ялангуяа мэргэшүүлж ажиллуулах, мөн боловсрол, мэргэжил, мэргэжлийн шаардлагыг тавихдаа салбарын онцлогтой тавих, мөн ялангуяа шинээр төрийн захиргааны албанд ажилд орж байгаа залуучуудын хувьд цалин хөлс, нийгмийн баталгааны асуудал нь илүү чухал авч үзэж байна гэж судалгааны дүн харагдсан.

Тэгэхээр хөдөлгөөний хувьд дундаж хөдөлгөөн нийт дунджаараа бодоход 10 орчим хувь байна. Тодруулаад аваад үзэх юм бол ялангуяа шинээр орж байгаа албан хаагчдын

Н.Энхболд: 2 номерын микрофоныг нэмчхээрэй. Саяын асуултуудыг нь нэмээд тодруулаад хариулаарай.

Ц.Амартөгс: Дундаж тоо нь байгаа дарга. Дэлгэрэнгүй нарийвчилсан тоог танд гаргаж хүргүүлж болно. Дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж хүргүүлье танд.

Н.Энхболд: Тодруулах уу Сүхээ гишүүн болсон уу? Хүчирхийлэлтэй холбоотой асуудал, 1 номерын микрофон. Төрийн албаны зөвлөлд их гомдол ирдэг юм л даа. Хүний эрхийн хороонд ирдэг л юм шиг байна лээ. Ёс зүй дээр ирэх ёстой. 1 номерын микрофон өгье ажлын хэсгийн. Битгий дараарай цаанаасаа өгөх ёстой байдаг юм. 1 номер ажлын хэсэг. Ажиллахгүй байгаа юм байх даа. Ирлээ болчихлоо.

Л.Цэдэвсүрэн: Сүхбаатар гишүүний асуултад хариулъя. Түүрүүний юун дээр бас тов тодорхой хэдэн тоо хэлье гишүүн. Өнөөдөр баг хорооны 1800 манай тоо бүртгэлд 1893 Засаг дарга байна. Энэнээс бакалаврын боловсролтой 1600, техник мэргэжлийн боловсролтой 104, магистр 14 хүн байна гэсэн ийм тоо бүртгэл байгаа. Бид нар яах вэ та бас мэдэж байгаа 2023 онд Боловсролын багц хуулийг батлуулахад дэд бакалавртай, дэд бакалавр гэдэг боловсролын зэргийн асуудлыг хуульчилсан. Тэгэхээр бакалавр, дэд бакалавртай болгох тал дээр нь бас хууль тогтоомжид өөрчлөлт оруулах юм бол баг, хорооны Засаг дарга маань нэлээн боловсролын түвшин дээр ахиц гарах болов уу л гэж бодож байна.

2023 онд энэ ёс зүйн хүрээнд сахилгын арга хэмжээ авагдсан 389

албан хаагч байгаа. Зөрчил илэрсэн гээд. Ноднингоос эхлээд манай дээр энэ бүртгэл бас хөтлөгдөж эхэлсэн. Ёс зүйн хороотой болж байгаа гэдэг агуулгаараа. Мэдээж бид нар Ёс зүйн дэд хороодынхоо бүх дүрэм, журмуудыг баталж өглөө. Ёс зүйн хороо яг бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж эхэлж байна. Тэгэхээр энэ ёс зүй ялангуяа хүчирхийлэл, энэ ажлын байрны элдэв асуудалтай холбоотой зүйлсийг Ёс зүйн хороон дээрээ нэлээн дүгнэлт хийж ажиллаж байгаа. Удахгүй Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороогоор Төрийн албан хаагчийн ёс зүй, эрсдэлээс сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг бас хэлэлцүүлэхээр ингээд төлөвлөөд явж байна. Маргааш 10-аас. Тийм, тэгэхээр энэ дээр бид нар бас нэлээн тодорхой арга хэмжээнүүдийг авахаар ингээд хөтөлбөрийнхөө төслийг боловсруулаад явж байна.

Н.Энхболд: Сүхбаатар гишүүний микрофон өгье. Тодруулна.

Ж.Сүхбаатар: Тэр юу шүү Цэдэвсүрэн дарга тэр тоогоо нягтлаарай. 1893 гэдэг чинь хороо ороогүй байх. Тэр багаараа л байгаа байх. Тийм багийн. Тэгэхээр өөрийн чинь хэлдгээр 1600 бакалаврын зэрэгтэй гэхцээр чинь үндсэндээ манайх дээд боловсролтой, миний уг нь тэр нэгжийн хууль чинь биелчхээд байгаа юм байна шүү дээ бараг. Манайхан чинь сүүлийн үед л энэ чинь хэцүү байна л гээд байсан. Тэгвэл 1893 багийн даргын 1600 нь үндсэндээ дээд боловсролтой л юм бол энэ чинь бараг л энэ чинь хэдэн хувьд байна 90 хувь руу дөхчихсөн байна уу?

Н.Энхболд: Бараг 80, 90 хувь болчихсон байна шүү дээ.

Ж.Сүхбаатар: Айн? Тэгвэл тухайн үед яаж байсан тэр тэгвэл асуудал биш л юм байна шүү дээ. Тэр хуулийн чинь заалтыг өөрчилье барья л гээд яваад байсан. Тэгвэл тэгэхдээ энийг нягтлаарай. Баг, хорооны Засаг дарга нарын дээд боловсролын асуудал дээр

тавигдах шаардлага гээд бид нар тавьчихсан байгаа Нэгжийн хууль дээр. Тэгэхээр үүнийг зарим нь бол тэр хүн хүн, хүн олдохгүй гээд яриад байдаг. Би бол олох ёстой. Хуулиа биелүүлэх хугацаанд дахиад 2 жилийн хугацаанд бэлдээрэй гээд л хэлсэн байхгүй юу. Тэгэхээр хэрвээ 1600 гээд таны энэ үндэстэй гэх юм бол би санаа зовохгүй.

Н.Энхболд: Ер нь бид нар бодлого тавьчихаад жоохон асуудал гарахаар тэрнээс буцаад айх бас их буруу л юм байгаа юм л даа уг нь бол. Би ганц асуулт асуучихъя.

Болчихсон уу? Микрофонгүй яриад хэлүүлчихье. Гишүүд асуулт асууж, үг хэллээ.

Би ганцхан юм асуучихъя. Энэ нэхэмжлэл гаргаж байна шүү дээ. Төрийн ажилтны буруугаас болоод төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлаар энэ дээр ийм тоонууд байх юм. 22 онд гэхэд жишээ нь шүүхэд манайх шүүхэд 457 сая төгрөгийг төлж, төрд учруулсан хохирлыг нөхөн төлөх шийдвэр гарсан. Тэрнээс 253 нь төлөгдсөн гэж байна. Энэ танай тайлангийн 10 дугаар хуудсан дээ. Мөн тийм байна. Энэ манай юуных дээр байна шүү Хяналтын юман дээр.

Хоёрдугаарт, Төрийг хохиролгүй болгох арга хэмжээ аваагүй 124 ажил албан тушаалтанд холбогдох тэрбум долоон зуун жаран дөрвөн сая төгрөгийн үнийн дүн бүхий хохирлыг нөхөн төлүүлэхээр төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Гэтэл энэнээс 451 нь л төлөгдсөн юм байна. Тэгэхээр энэ энэ юунаас болоод байна? Бид нар нэхэмжлэхээ тавихдаа буруу тавиад байна уу, эс үгүй бол шүүх дээр очсон хойно асуудлыг жишээ нь Төрийн албаны зөвлөлөөс буруу үнэлж, буруу хохирол төлүүлэх гээд тавьсан байна. Тийм учраас тэрнээс нь 2 дахин шахуу бага төлбөр төлүүлэх ёстой гэсэн ийм шийдвэр гараад байна уу энэ асуудал юундаа байна? Энэ дээр товчхон

хариулчихвал. Идэрчулуун гишүүн үү? 1 номер баярлалаа.

Б.Идэрчулуун: Та бүхэнд энэ өдрийн мэнд дэвшүүлье. Энэ ийм байгаа юм дарга бид нар бол шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гараад, ажлаас үндэслэлгүй халагдсан, эс үгүй бол чөлөөлсөн эс үгүй бол чөлөөлсөн ийм шийдвэрийн жагсаалт нь манайд ирж байгаа. Энэ оноор нь ярих юм бол үндсэндээ бид нарыг ажил авахад 19 он гэхэд тэрнээс өмнөх нийт том дүнгээр нь яривал учиргүй том тоо байдаг юм байна лээ. 45 тэрбум төгрөг гэж Хууль зүйн сайдын багцаас жил болгон 2, 2 тэрбумаар тавигдаад явсан энэ их төлбөр юм байна лээ.

Бид нар шүүхэд энэ шүүхийн хүчин төгөлдөр шийдвэртэй Доржийг ажлаас үндэслэлгүй халсныг нь шүүх тогтоогоод, ажилгүй байсан хугацааны цалинг олго гээд үнийн дүнтэй ингээд 3 шатын шүүхийн эцсийн шийдвэрийг Төрийн албаны зөвлөлд ирэхээр нь бид нар энэ мөнгөн дүнгээ та төл гээд тэр буруутай шийдвэр гаргасан албан тушаалд нь мэдэгдэл хүргүүлж байгаа эхлээд.

Тэгээд тэрийг авчхаад зарим нь наадах чинь би халах ёстой хүнийг халсан, би шүүх дээр маргалдана гэж яваад очоод шийдүүлж байгаа ч байна. Зарим нь хөөн хэлэлцэх хугацаа гэдэг асуудал Иргэний хууль дээр заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрчихсөнийг бол бид нар яаж ч чадахгүй л хаяхаас өөр аргагүй юм билээ. Одоо бол энэ бид нарын яриад байгаа энэ тэрбум найман зуун хэдэн сая бол ухаандаа хуулийнхаа хөөн хэлэлцэх хугацаандаа багтаж байгаа, дандаа дарга нартай холбоотой ийм шийдвэрийг одоо ингээд нэхэмжлэл маягаар бид нар шүүхэд гаргачхаад, тэр дээр шүүх ахиад шийдвэр гаргаж байгаа юм. Тэгэхдээ энэ дундаас нь бас нэг хэсэг нь хасагдана. Ямар нь хасагдаж байна вэ гэхээрээ 2 тал хоорондоо эвлэрээд тэгсэн хэр нь хохирол гаргачихсан, жил гаран ажилгүй явчихсан, 2 жил ажилгүй явчихсан.

Тэгэнгүүт захиргаа нь тухайн хүнтэйгээ эвлэрээд гаргачихсан үнийн дүнг эргээд шүүх бол авч хэлэлцэхгүй энэний энэ гэм бурууг нь шүүх тогтоогоогүй.

Тийм учраас нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болголоо гээд явж байгаа юм байгаа юм. Саяын энэ таны ярьдаг энэ 451 сая бол үндсэндээ бид нар энэ шинэ хуулийн хүрээнд анхны жил нь жоохон тоо хөдөлгөсөн. Сая өнгөрсөн жил бол бас 253 сая төгрөгийг төлүүлчихсэн. Тэгээд үүний ардаас эргээд хүмүүс нь хөөцөлдөхөөр бид нар чинь ингээд нотлох баримт бүрдүүлэхэд гэхэд л нотариатын зардал гээд замбараагүй өндөр зардал гарч байгаа. Зарим аймаг бол хүрч ирж заавал шүүх хуралдаанд орно. Тэгэхгүй бол өөрийн биеэр ирж та нар энэ хэргийн материалтай танилцахгүй бол энэ нэхэмжлэлийг чинь буцаалаа эд нар гээд л бол зовлон бол их байдаг юм байна. Яг адилхан хоёр нэхэмжлэл өгөхөд зэрэгцээд сууж байгаа нэг шүүгч нь буцаагаад нэг нь нөгөөдхийг нь аваад шийдэх жишээтэй. Тэгэхдээ үндсэндээ бол яах вэ? Бид нар Захиргааны ерөнхий хууль орсноос хойших хугацаа үндсэндээ 17 оноос хойших шийдвэрүүдийг яг энэнийхээ ардаас хөөцөлдөөд явж байгаа.

Н.Энхболд: Баярлалаа. Гишүүд тайлан шинжилгээний дүн хоёртой холбогдуулж асууж, үг хэлж дууслаа.

Тэгэхээр өнгөрсөн 22 оны ажлын тайланг Улсын Их Хурлаар хэлэлцэж байсан. Тэн дээр бас тодорхой зүйлүүд яригдсан. Энэ удаа 23 оны тайлангаа бид нар сонслоо. Энэ дээр нэг зүйлүүдийг хэд хэдэн чиглэлээр ийм арга хэмжээ авах саналтай байна гээд тайлан дээр ч тэр, манай шинжилгээ дээр ч гарч байна. Тэгэхээр энийг чиглэл чиглэлээр нь хэн, хаана ямар арга хэмжээ авах ёстой юм ямар хууль тогтоомжийг боловсронгуй болгох ёстой юм үүнийг Ерөнхийлөгчийн зүгээс жишээ нь ийм зүйл, Их Хурлын зүгээс ийм зүйл, Засгийн газрын зүгээс ийм зүйл хийх хэрэгтэй байна гэдгээ өнөөдөр энэ хэлэлцэснийхээ дагуу манай

Байнгын хорооны ажлын хэсэг, ахлах, Ганболд дарга 3 газар нийлж байгаад яг өнөөдөр танилцуулсан гишүүдийн асуусан санаа оноогоо хэлсэн тэр хүрээнд байгууллага байгууллагаар нь ингээд гаргаад ирье.

Жишээ нь Их Хурал юу хийх хэрэгтэй байна, ямар хууль хэрэгтэй, хийх хэрэгтэй байгаа юм, тэгэхийн тулд тэр хуулийг нь хэн санаачлах юм, танайхаас байх юм уу, Засгийн газраас байх юм уу гээд бүүр тодорхой ийм асуудлуудаа оруулаад ирье. Тэгээд Байнгын хорооны зүгээс энэ газруудад нь чиглэл чиглэл өгөөд албан шийдвэрүүд ингээд явуулчихъя. Тэрний дагуу хугацаатай үүрэг байгууллага болгонд өгөөд ингээд өнөөдрийнхөө тайлангийн дүнгээр цаашид ямар арга хэмжээнүүд авах вэ гэдгээ тодруулчихъя.

Би бол бодож байна. Өнгөрсөн жил бид нар Их Хурлаар тайланг албан ёсоор Их Хурлын чуулганаар сонссон. Энэ хооронд бас нэлээн том үйл явдлууд болоод шинээр манайх хуультай болоод ёс зүйн тийм ээ? Цоо шинэ бүрэлдэхүүн манай Төрийн албаны зөвлөлийн дэргэд Ёс зүйн хороотой боллоо. Дэд хороонуудаа байгуулах ерөнхий сууриудаа тавьчихлаа. Чиглэл бол цаашидаа би Улсын Их Хурлаас ямар чиглэл гаргах ёстой бол гэдэг дээр ийм л юм бодож байна. Заавал чуулганаа хэлэлцүүлэлгүйгээр Байнгын хорооны түвшинд яриад, хамгийн том чиглэл бол энэ салбар хороод, Төрийн албаны зөвлөлийн салбар хороод ёс зүйн дэд хорооддоо нэлээд тийм эрх өгсөн, үүрэг ноогдуулсан хариуцлагыг нь тэндээ үүрдэг ийм тогтолцоо руу бид нар алхам алхмаар шилжих хэрэгтэй юм байна. 93 онд энэ шинэ нийгмийн шаардлагад нийцүүлээд төрийн албыг шинэчлэх ажил эхэлсэн. Хууль нь хэд хэдэн урд удаа гарлаа. Олон удаа өөрчлөлт орлоо.

Тэгэхдээ дандаа хэдийгээр алдаа оноотой зүйл байсан ч гэсэн ерөнхийдөө энэ ардчилсан чөлөөт нийгмийн үед төрийн алба ямар байх ёстой юм гэдгийг

алхам алхмаар урагшлуулсан ийм л шийдвэрүүд гарч яваг ирсэн гэж ингэж ойлгож байгаа. Энэнд орсон томоохон өөрчлөлтүүд одоо сая миний хэлсэн ёс зүйтэй холбоотой асуудал. Нийгмийн шаардлага ч тийм болоод ирлээ.

Ер нь ч аль ч улсын ямар ч төрийн алба бонд энэ ёс зүйтэй байх бол хамгийн том суурь дэвсгэр шаардлага байна гэдэг нь ингээд харагдаж байгаа учраас энэ чиглэлээр хийсэн энэ ажлууд юмны үр дүн бас бүрэн гүйцэд гараагүй байна. Ажил одоо л эхэлж байна. Саяхан бид нар дэд хороодоо хороогоо байгуулаад дэд хороодынхоо журмыг батлаад одоо ингээд Үндэсний хөтөлбөрөө батлаад явах гэж байна. Энэ өөрөө тэр яг төрийн албаны бүх л шатад, бүх л нэгж давхаргуудад бүгдэд нь хамгийн гол суурь болж явах ёстой ийм асуудал болж байгаа.

Тэгэхээр энд нэлээд чиглэсэн энэ асуудлуудаа, дээр нь сая тэр зохион байгуулалттай, бүтэцтэй холбоотой ажлын шаардлагаар тухайлбал тэр судалгааны нэгдсэн сангийн тухай асуудал байна шүү дээ. Тийм энэ юмнууд үнэхээр хэрэгтэй гэж үзэж байгаа бол ярилцаад хэн асуудал шийдэх шийдэх ёстой юм тэрэнд нь чиглэл өгсөн тэр саналуудаа саяын миний хэлсэн 3 байгууллага хамт сууж байгаад одоо нэгэнт ингээд ярьчихсан юм чинь бараг энэ 7 хоногтоо багтаад эцэслэчихвэл бид нар 7 хоногийн сүүлээр Байнгын хорооныхоо зүгээс тэр холбогдох газруудад нь бичгийг нь явуулчихъя. Одоо чуулганаар хэлэлцэх шаардлагагүй болов уу гэж би бодож байна. Байнгын хороон дээрээ ингээд сонсчихъё үүрэг чиглэлээ Байнгын хорооноосоо өгчихье гэсэн ийм бодолтой байна.

Тайлангаа ирүүлсэн, тайлангаа тавьсан, хуралдаанд оролцсон байгууллагууд, дүн шинжилгээ хийсэн газрууд нийт хүмүүст баярлалаа.

Өнөөдөр Төрийн албаны зөвлөлийн 2023 оны тайланг Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцэж дууслаа.

Хуралдаанд оролцсон хүмүүст баярлалаа.

Маргаашаас эхлээд саяынхаа юмнууд дээр хамт суугаарай Цэдэвсүрэн дарга, Ганболдоо, Хатантуултай хамт.

Баярлалаа. Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье.

15.54 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР